



ᠬᠤᠭᠤᠬᠡᠳᠤ, ᠵᠠᠯᠤᠭᠤᠴᠤᠭᠤ

ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД



1

БОЛОВСРОЛ,
БИЧИГ ҮСГИЙН
МЭДЛЭГ

2

ШИЛЖИХ,
ХӨДӨЛГӨӨН,
СҮҮРЬШИЛ

3

ӨНДӨР
НАСТАЙ

4

ӨРХ-ГЭР
БУЛИЙН БАЙДАЛ,
ГЭРЛЭЛТ

5

ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭД

6

ХӨНДӨРЛИЙН
ТЭГШ БАЙДАЛ

7

ОРОН СУУЦНЫ
АХУЙН НӨХЦӨЛ

8

ИНТЕРНЕТ,
ГАР УТАСНЫ
ХЭРЭГЛЭЭ

10

ЭДИЙН ЗАСЛИЙН
ИДЭВХ

11

ХҮН АМЫН ТОО
ХҮН АМЫН
ХЭТИЙН ТООЦОО
2010-2040

12

МЯНГАНЫ
ХӨГЖЛИЙН
ЗӨРИЛГҮЙН
ЗӨРИЛГҮЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД

Улаанбаатар хот
2011 он

DDC
305.23'021'517
X-856

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
<http://www.nso.mn>
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

ISBN 978-99929-64-73-1

АГУУЛГА

Судалгаа бичихэд оролцогчид.....	iv
Хүснэгтийн жагсаалт.....	v
Зургийн жагсаалт.....	viii
Хавсралт хүснэгтийн жагсаалт.....	ix
Товчилсон үгийн тайлбар	x
Өмнөх үг.....	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Удиртгал	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хүүхэд, залуучуудын ерөнхий төрх	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Хүүхэд	27
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Залуучууд.....	49
ТАВДУГААР БҮЛЭГ. Залуучуудын эдийн засгийн идэвх	69
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. Бүс нутгийн болон аймгуудын ялгаа	85
Дүгнэлт, зөвлөмж.....	93
Хавсралт	97



СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Бямбын Саранчимэг

Статистикч

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын орлогч дарга

Содбаатарын Тодгэрэл

Эдийн засагч - Хүн ам зүйч

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын шинжээч

ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

Баатарын Эрдэнэсүрэн

Үйлдвэрийн инженер - эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор, профессор

ҮСХ-ны дэд дарга

Балжмаагийн Ганбат

Статистикч, Эдийн засгийн ухааны доктор

ҮСХ-ны Ерөнхий менежер, Тамгын газрын дарга

Бидэрьяагийн Цэрэнханд

Программ зохиогч, Тооцоолох техникийн инженер

ҮСХ-ны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга

ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Ганбаатарын Урангоо

Бизнесийн удирдлага, санхүүгийн менежер

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1. 0-24 насны хүүхэд, залуучууд, нийт хүн амд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 1989, 2000, 2010 он	12
Хүснэгт 2.2. 0-24 насны хүүхэд, залуучуудын тоо, насны бүлэг, хүйс, байршлаар, 2010 он.....	14
Хүснэгт 2.3. 0-24 насны хүүхэд, залуучуудын тоо, нийт дүнд эзлэх хувь, насны бүлэг, үндэс угсаагаар, 2000, 2010 он	16
Хүснэгт 2.4. 0-24 насны хүүхэд, залуучуудын тоо, насны бүлэг, хүйс, үндэс угсаагаар, 2000, 2010 он.....	17
Хүснэгт 3.1. 2-5 насны хүүхдийн тоо, нас, хүйс, цэцэрлэгт хүмүүждэг эсэхээр, 2010 он	31
Хүснэгт 3.2. Цэцэрлэгт хүмүүждэг 2-5 насны хүүхдийн тоо, нийт дүнд эзлэх хувь, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	32
Хүснэгт 3.3. Цэцэрлэгт хүмүүждэггүй 2-5 насны хүүхдийн тоо, нийт дүнд эзлэх хувь, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	32
Хүснэгт 3.4. Сургуульд суралцдаг 6-14 насны хүүхдийн тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он..	33
Хүснэгт 3.5. 7-14 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хувиар, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он.....	33
Хүснэгт 3.6. Сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, 2010 он	37
Хүснэгт 3.7. 16 хүртэлх насны хүүхэдтэй өрх, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он	39
Хүснэгт 3.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, нийт дүнд эзлэх хувь, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он.....	43
Хүснэгт 3.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийт дүнд эзлэх хувь, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он.....	44
Хүснэгт 4.1. 15-24 насны залуучуудын гэрлэлтийн байдал, нийт дүнд эзлэх хувь, хүйс, тооллого явагдсан онуудаар	51
Хүснэгт 4.2. 15-24 насны цуцалсан, бэлэвсэн залуучууд, дүнд эзлэх хувиар, хүйсээр, тооллого явагдсан онуудаар	53
Хүснэгт 4.3. Тоологдсон газартаа шилжиж ирээд 5-6 жил оршин сууж буй 15-24 насны залуучуудын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он	55
Хүснэгт 4.4. Сүүлийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцсон 15-24 насны залуучууд, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....	56
Хүснэгт 4.5. 15-24 насны залуучуудын сургуульд хамрагдалтын хувь, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он	60
Хүснэгт 4.6. Суурь болон бүрэн дунд боловсролын сургуульд суралцагчид, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	61
Хүснэгт 4.7. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын тоо, бэрхшээлийн хэлбэр, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	64
Хүснэгт 4.8. Хөгжлийн олдмол бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын тоо, бэрхшээлийн хэлбэр, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	65
Хүснэгт 5.1. 15-24 насны залуучуудын эдийн засгийн идэвх, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2010 он.....	70
Хүснэгт 5.2. 15-24 насны залуучуудын эдийн засгийн идэвх, насны бүлэг, хүйс, хувиар, 2010 он.....	70
Хүснэгт 5.3. 15-24 насны ажил эрхэлдэг залуучууд, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	72
Хүснэгт 5.4. 15-24 насны ажил эрхэлдэг залуучуудын тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	72
Хүснэгт 5.5. 15-24 насны ажил эрхэлдэг залуучуудын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он	72



Хүснэгт 5.6. Ажил эрхэлдэг 15-24 насны залуучуудын тоо, насны бүлэг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2010 он	73
Хүснэгт 5.7. 15-24 насны залуучуудын ажил эрхлэлт, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2010 он	74
Хүснэгт 5.8. Ажил эрхэлдэг залуучуудын тоо, насны бүлэг, хүйс, гэрлэлтийн байдлаар, 2010 он	77
Хүснэгт 5.9. Ажилгүй залуучууд, ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйс, хот хөдөөгөөр, 2000, 2010 он.....	80
Хүснэгт 5.10.Тохирох ажил олдохгүйгээс ажилгүй байгаа залуучуудын тоо, насны бүлэг, хот хөдөөгөөр, 2000, 2010 он.....	80
Хүснэгт 5.11. Ажил хайж байгаа залуучуудын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он	81
Хүснэгт 5.12. Ажил хайж байгаа залуучуудын тоо, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он	81
Хүснэгт 5.13. Ажил хайж байгаа залуучуудын тоо, ажилгүйдлийн түвшин, хүйс, насны бүлэг, боловсролын түвшингээр, 2010 он	82
Хүснэгт 6.1. Хүүхэд, залуучуудын тоо, насны бүлэг, бүсээр, 2010 он	86
Хүснэгт 6.2. 15-24 насны эдийн засгийн идэвхгүй залуучууд, нийт дүнд эзлэх хувиар, шалтгаан, аймгаар, 2010 он.....	92

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1. Хүүхэд, залуучуудын тоо, тооллого хоорондын өсөлтийн хувь	10
Зураг 2.2. 0-24 насны хүүхэд, залуучуудын тооны тооллого хоорондын өсөлт, хувь, тооллого явагдсан онуудаар	11
Зураг 2.3. 0-24 насны хүүхэд, залуучууд, нийт хүн амд эзлэх хувь, тооллого явагдсан онуудаар	11
Зураг 2.4. 0-24 насны хүүхэд, залуучуудын хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2000, 2010 он	13
Зураг 2.5. 0-24 насны хүүхэд, залуучуудын нас, хүйсийн суварга, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он	13
Зураг 2.6. 0-24 насны хүүхэд, залуучууд, байршлаар, 2010 он	14
Зураг 2.7. 0-24 насны хүүхэд, залуучуудын нас, хүйсийн бүтэц, иргэний харьяаллаар, 2010 он.....	15
Зураг 2.8. Гадаадын харьяат хүүхэд, залуучууд, улсаар, хувиар, 2010 он.....	16
Зураг 2.9. 0-24 насны хүүхэд, залуучууд тоо, үндэс угсаа, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	18
Зураг 2.10. Залуучуудын шашин шүтлэгийн байдал, нас, хүйсээр, 2010 он	19
Зураг 2.11. Буддын шашин шүтдэг залуучуудын тоо, нас, хүйсээр, 2010 он.....	19
Зураг 2.12. Шашин шүтдэг залуучууд, насны бүлэг, хүйс, шашны урсгалаар, 2010 он	20
Зураг 2.13. Шашин шүтдэг залуучууд, нас, хот, хөдөөгөөр, 2010 он.....	20
Зураг 2.14. Шашин шүтдэг залуучууд, дүнд эзлэх хувь, хот, хөдөө, шашны урсгалаар, 2010 он.....	21
Зураг 2.15. 0-18 насны хүүхэдтэй өрх, өрхөд тоологдсон хүүхдийн тоо, дүнд эзлэх хувиар, 2010 он	21
Зураг 2.16. 0-18 насны хүүхэдтэй өрх, өрхөд тоологдсон хүүхдийн тоо, сууцны төрлөөр, 2010 он.....	22
Зураг 2.17. Байшинд амьдардаг 0-18 насны хүүхэдтэй өрхийн тоо, өрхөд тоологдсон хүүхдийн тоо, байшингийн төрлөөр, 2010 он	22
Зураг 2.18. 0-18 насны хүүхэдтэй өрхийн тоо, ундны усны эх үүсвэрээр, 2010 он.....	23
Зураг 2.19. 0-18 насны хүүхэд, залуучуудын тоо, насны бүлэг, ундны усаа авдаг зайгаар, 2010 он	24

Зураг 2.20.	0-18 насны хүүхэдтэй өрхийн тоо, хүүхдийн насны бүлэг, хоол ундаа ихэвчлэн болгодог түлшний төрлөөр, хувиар, 2010 он.....	24
Зураг 2.21.	Өрх тэргүүлэн амьдарч байгаа 15-24 насны залуучуудын тоо, хүйс, сууцны эзэмшлээр, 2010 он	25
Зураг 2.22.	Өрх тэргүүлэн амьдарч байгаа 15-24 насны залуучуудын тоо, сууцны төрөл, эзэмшлээр, 2010 он	25
Зураг 3.1.	0-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	28
Зураг 3.2.	6-14 насны хүүхдийн тоо, нас, бичиг үсгийн мэдлэг, хувиар, 2010 он	29
Зураг 3.3.	6-14 насны хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он	30
Зураг 3.4.	6-14 насны хүүхдийн тоо, нас, хот, хөдөө, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он	30
Зураг 3.5.	6-11 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он	34
Зураг 3.6.	12-15 насны хүүхдийн суурь боловсролд хамрагдалт, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он	35
Зураг 3.7.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц, 2010 он	36
Зураг 3.8.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн тоо, хүйс, бүсээр, 2010 он.....	36
Зураг 3.9.	0-17 насны хүүхэд, нийт дүнд эзлэх хувиар, эцэг, эхтэйгээ амьдардаг эсэх, хот, хөдөөгөөр, 2010 он.....	38
Зураг 3.10.	Эцэг, эхээсээ бусад асран хамгаалагчтай амьдарч байгаа 18 хүртэлх насны хүүхэд, нийт дүнд эзлэх хувь, асран хамгаалагч, хот, хөдөөгөөр, 2010 он	39
Зураг 3.11.	16 хүртэлх насны хүүхэдтэй өрх, хүүхдийн тоо, хот, хөдөөгөөр, 2010 он	40
Зураг 3.12.	Гадаадад төрсөн Монгол Улсын харьяат 0-14 насны хүүхэд, дүнд эзлэх хувь, үндсэн нэгждээ амьдарч буй хугацаагаар, 2010 он	41
Зураг 3.13.	Гар утас хэрэглэдэг 6-14 насны хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц, 2010 он.....	42
Зураг 3.14.	Интернет хэрэглэдэг 6-14 насны хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц, 2010 он	42
Зураг 3.15.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010 он	43
Зураг 3.16.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, нийт дүнд эзлэх хувиар, 2010 он	44
Зураг 3.17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийт дүнд эзлэх хувь, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он	45
Зураг 3.18.	Хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэддэг хүүхдийн тоо, нас, хүйсээр, 2010 он	45
Зураг 3.19.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн СӨБ-д хамрагдалт, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	46
Зураг 3.20.	Сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, нас, хүйсээр, 2010 он...	46
Зураг 3.21.	Сургуульд сурдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр, 2010 он.....	47
Зураг 3.22.	Хөгжлийн бэрхшээлтэй бага боловсролтой хүүхдийн тоо, нас, хүйсээр, 2010 он.....	47
Зураг 4.1.	Анхны гэрлэлтийн дундаж нас, хүйсээр, тооллого явагдсан онуудаар	50
Зураг 4.2.	Огт гэрлээгүй залуучуудын нас, хүйсийн суварга, 2010 он	52
Зураг 4.3.	Гэр бүлтэй залуучуудын нас, хүйсийн бүтэц, 2010 он	52
Зураг 4.4.	Өрх тэргүүлэн амьдарч байгаа залуучууд, нас, гэрлэлтийн байдлаар, 2010 он	54
Зураг 4.5.	Гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат 15-24 насны залуучуудын нас, хүйсийн бүтэц, 2010 он.....	55
Зураг 4.6.	Гадаадад төрсөн Монгол Улсын харьяат 15-24 насны залуучуудын тоо, насны бүлэг, үндсэн нэгждээ амьдарч буй хугацаагаар, 2010 он.....	56
Зураг 4.7.	15-24 насны залуучуудын бичиг үсгийн мэдлэг, хувиар, сонгосон орнуудаар, 2009 он.....	57



Зураг 4.8.	15-24 насны залуучуудын бичиг үсгийн мэдлэг, хувь, насны бүлэг, тооллого явагдсан онуудаар	58
Зураг 4.9.	Бичиг үсэг мэддэг 15-24 насны залуучуудын тоо, насны бүлэг, хүйс, тооллого явагдсан онуудаар	58
Зураг 4.10.	Бичиг үсэг мэддэг 15-24 насны залуучуудын тоо, нас, хот, хөдөөгөөр, 2010 он	59
Зураг 4.11.	Сургуульд суралцдаг 15-24 насны залуучуудын нас, хүйсийн бүтэц, 2010 он	60
Зураг 4.12.	15-24 насны хүн амын боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, хүйсээр, 2010 он	61
Зураг 4.13.	Гар утас, интернет хэрэглэдэг залуучуудын нас, хүйсийн бүтэц, 2010 он	62
Зураг 4.14.	Гар утас хэрэглэдэг залуучуудын тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	62
Зураг 4.15.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, дүнд эзлэх хувь, насны бүлэг, бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он	63
Зураг 4.16.	Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын тоо, бэрхшээлийн хэлбэрээр, 2010 он	63
Зураг 4.17.	Хөгжлийн олдмол бэрхшээлтэй залуучуудын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....	64
Зураг 4.18.	Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын тоо, хүйс, гэрлэлтийн байдлаар, 2010 он	65
Зураг 4.19.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бичиг үсгийн мэдлэг, хувь, насаар, 2010 он	66
Зураг 4.20.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нас, хүйсийн бүтэц, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он	66
Зураг 4.21.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сургуульд хамрагдалт, хувь, нас, хүйсээр, 2010 он	67
Зураг 4.22.	Сургуульд суралцдаг, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	67
Зураг 4.23.	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын боловсролын түвшин, хувиар, 2010 он	68
Зураг 4.24.	Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын тоо, хүйс, боловсролын түвшнээр, 2010 он.....	68
Зураг 5.1.	15-24 насны залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин, хувь, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он.....	71
Зураг 5.2.	15-24 насны залуучуудын ажил эрхлэлт, насны бүлэг, ажил эрхлэлтийн статусаар, 2010 он	75
Зураг 5.3.	Ажил эрхэлдэг 15-24 насны залуучуудын тоо, насны бүлэг, боловсролын түвшингээр, 2010 он	75
Зураг 5.4.	Залуучуудын ажил эрхлэлт, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, 2010 он	76
Зураг 5.5.	Ажил эрхэлдэг залуучууд, хувиар, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар, 2010 он.....	76
Зураг 5.6.	Хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ сургуульд сурдаг залуучуудын нас, хүйсийн бүтэц, 2010 он.....	77
Зураг 5.7.	Хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ сургуульд сурдаг залуучуудын нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр, 2010 он	78
Зураг 5.8.	Ажил эрхэлдэг, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тоо, насны бүлэг, ажил эрхлэлтийн статусаар, 2010 он	78
Зураг 5.9.	Ажил эрхэлдэг, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тоо, насны бүлэг, ажил эрхлэлтийн статус, хот, хөдөөгөөр, 2010 он	79
Зураг 5.10.	Тохирох ажил олдохгүйгээс ажилгүй байгаа залуучууд, насны бүлэг, байршлаар, 2010 он	81
Зураг 5.11.	Ажил хайж байгаа залуучууд, дүнд эзлэх хувь, хүйс, боловсролын түвшингээр, 2010 он	82
Зураг 5.12.	Ажил хайж байгаа залуучуудын ажилгүйдлийн түвшин, хүйс, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, 2010 он	83
Зураг 5.13.	Эдийн засгийн идэвхгүй залуучууд, хувиар, шалтгаанаар, 2010 он	83

Зураг 5.14.	Эдийн засгийн идэвхгүй залуучууд, насны бүлэг, шалтгаанаар, 2010 он.....	84
Зураг 5.15.	Ажиллах сонирхолгүй залуучуудын нас, хүйсийн бүтэц, 2010 он	84
Зураг 6.1.	Нийт хүн амд хүүхэд, залуучуудын эзлэх хувь, насны бүлэг, бүсээр, 2010 он.....	87
Зураг 6.2.	15-24 насны залуучуудын хүйсийн харьцаа, аймгаар, 2010 он	87
Зураг 6.3.	Бага боловсролын шатны сургуульд суралцагчид, дүнд эзлэх хувь, аймаг, хувиар, 2010 он.....	88
Зураг 6.4.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувь, хүйсийн харьцаа, бүсээр, 2010 он.....	89
Зураг 6.5.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхэд, тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувиар, аймаг, хувиар, 2010 он.....	89
Зураг 6.6.	Эдийн засгийн идэвхтэй 15-24 насны залуучууд, нийт дүнд эзлэх хувь, бүсээр, 2010 он	90
Зураг 6.7.	Эдийн засгийн идэвхтэй 15-24 насны залуучууд, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, аймаг, нийслэл, хувиар, 2010 он.....	90
Зураг 6.8.	Эдийн засгийн идэвхтэй 15-24 насны залуучууд, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, нас, хүйсээр, аймаг нийслэлээр, 2010 он.....	91
Зураг 6.9.	15-24 насны хөдөлмөр эрхэлдэг залуучууд, дүнд эзлэх хувиар, хөдөлмөр эрхлэлтийн байдал, бүсээр, 2010 он	92

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	0-24 насны суурин хүн амын тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	98
Хүснэгт 2.	0-24 насны суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	99
Хүснэгт 2А.	Хотын 0-24 насны суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	100
Хүснэгт 2Б.	Хөдөөгийн 0-24 насны суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	101
Хүснэгт 3.	Монгол улсын харьяат 0-24 насны иргэдийн тоо, үндэс угсаа, насны бүлгээр, 2010 он	102
Хүснэгт 4.	15-24 насны хүн амын тоо, гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	102
Хүснэгт 5.	15-24 насны суурин хүн амын тоо, нас, хүйс, шашны урсгал, хот, хөдөөгөөр, 2010 он.....	103
Хүснэгт 6.	6-24 насны хүн амын тоо, боловсролын түвшин, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	104
Хүснэгт 7.	6-24 насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	105
Хүснэгт 8.	Суурь, бүрэн дунд боловсрол, МСҮТ-д хамрагддаг хүн амын тоо, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	105
Хүснэгт 9.	2-24 насны хүн амын тоо, сургуульд хамрагдалт, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	106
Хүснэгт 10.	6-15 насны хүн амын тоо, сургуульд хамрагдалт, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он	107
Хүснэгт 11.	Бага боловсролын шатны сургуульд хамрагддаг 6-11 насны хүн амын тоо, хүйс, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он.....	107
Хүснэгт 12.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	108

Хүснэгт 13.	0-24 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, насны бүлэг, аймаг нийслэлээр, 2010 он	108
Хүснэгт 14.	0-24 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, насны бүлгээр 2010 он	109
Хүснэгт 15.	15-24 насны хүн амын тоо, эдийн засгийн идэвх, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	109
Хүснэгт 16.	15-24 насны ажил эрхэлдэг хүн амын тоо, ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он	110
Хүснэгт 17.	6-24 насны хүн амын гар утас болон интернетийн хэрэглээ, насны бүлэг, хүйсээр, 2010 он	110
Хүснэгт 18.	18 хүртэлх насны суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйс, эцэг, эхтэйгээ хамт амьдардаг байдлаар, хот, хөдөөгөөр, 2010 он	111
Хүснэгт 19.	18 хүртэлх насны суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйс, эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй байдлаар, хот, хөдөөгөөр, 2010 он	111
Хүснэгт 20.	0-14 насны хүүхдийн тоо, амьдарч байгаа өрхийн шинж байдлаар, сургуульд суралцаж / цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхээр, 2010 он	112
Хүснэгт 21.	15-24 насны залуучуудын тоо амьдарч буй өрхийн шинж байдлаар, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, 2010 он	112
Хүснэгт 22.	15-24 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн тоо, сууцны төрлөөр, сууцны өмчийн хэлбэр, эзэмшлийн хэлбэрээр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	113
Хүснэгт 23.	Хүүхэдтэй өрх, тухайн өрхөд амьдарч буй хүүхдийн тоо, орон сууцны нөхцлөөр, хүүхдийн насаар, 2010 он	114

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнг төр, засгийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллагууд, өргөн олон хэрэглэгчдэд хүргэх нь Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны гол зорилт бөгөөд энэхүү тооллогын дүнгээр гаргаж байгаа сэдэвчилсэн судалгаануудын нэг болох “Хүүхэд, залуучууд” судалгааг хэрэглэгчдийн гар дээр хүргэж байна.

Хүүхэд, залуучууд нь хүн амын доторх хамгийн идэвхтэй, өөрчлөмтгий хэсэг бөгөөд тэдний тоо, бүтэц, байршил нь хүн амын төрөлт, нас баралт үүний дотор нялхсын болон хүүхдийн нас баралтын үе үеийн түвшин, шилжих хөдөлгөөнтэй нягт уялдаатайгаар өөрчлөгдөж байдаг. Түүнчлэн тооллогын дүнгээр манай улсын 10 хүн тутмын 5 нь 0-24 насны хүүхэд, залуучууд байгаа учир

тэдний ерөнхий дүр төрх, эдийн засгийн идэвх, боловсролын түвшин зэрэгт сүүлийн 10 жилд гарсан өөрчлөлтийг харуулсан, XXI зууны нийгмийн идэвхтэй хэсгийн талаар баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулахад шаардлагатай суурь материал бүрдүүлэх зорилгоор энэ судалгааг хийлээ.

Энэхүү судалгаанд хүүхэд, залуучуудын тоо, бүтцийн өөрчлөлт төдийгүй тэдний гэрлэлт, орон сууцны нөхцөл, сургуульд хамрагдалт, боловсрол, эдийн засгийн идэвх, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллүүдийг нас, хүйс, байршлаар тусгасан нь хүүхэд, залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, төслийг залуучуудын хэрэгцээ, шаардлагад үндэслэн тэдэнд өгөөжтэйгээр боловсруулж, тэдний өмнө тулгамдсан асуудлыг оновчтой шийдвэрлэхэд ач холбогдолтой мэдээлэл болно гэж үзэж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

 С.МЭНДСАЙХАН

НЭГЛҮГЭЭР БҮЛЭГ

УДИРТГАЛ



1.1. ЗОРИЛГО

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнг үндэслэн төрөл бүрийн сэдэвчилсэн судалгаа хийж байгаагийн нэг нь “Хүүхэд, залуучууд” судалгаа юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци, Монгол Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуульд 18 хүртэлх насны хүн амыг хүүхэд гэж заасан бол, НҮБ-аас гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын удирдамж, зарчмууд”-ын 3.97-д “Статистикийн зорилгоор “хүүхэд” гэдэгт 15-аас доош насны хүн ам, “залуучууд” гэдэгт 15-24 насны хүн амыг хамааруулж ойлгоно. Гэхдээ хүн амын эдгээр тусгайлсан бүлгүүдийг 5 насны бүлгээр хуваах нь зүйтэй, учир нь энэ насны бүлгийн хүн амын сургуульд хамрагдалт, гэрлэлтийн байдал, үйл ажиллагаа гэх зэрэг шинж төрхүүд нь хурдан өөрчлөгддөг юм...” гэж заасан олон улсын нийтлэг жишгийг харгалзан, өмнөх тооллогуудын дүнд үндэслэн хийгдсэн судалгаануудтай харьцуулах үүднээс 0-14 насны хүн амыг “хүүхэд”, 15-24 насны хүн амыг “залуучууд” гэж авлаа.

Хүн ам зүйн шинжлэх ухаан аливаа улсын хүн амын насны бүтэц нь залуужих, идэрших, хөгшрөх гэсэн гурван үндсэн хандлагатай гэж үздэг. Манай улсын хүн амын 50.7 хувь нь 1979 оны тооллогоор хөдөлмөрийн насных байсан бол 2010 онд 68.3 хувьд хүрчээ. Хүн ам зүйн ачаалал буурч, хүн амын насны бүтэц идэршин, хөдөлмөрийн насны хүн амын тоо эрс нэмэгдэхийг “хүн ам зүйн цонх үе” гэдэг. Манай улсад “хүн ам зүйн цонх үе” тохиож байгаа нь ажлын байрыг олноор нэмэгдүүлэх, ажиллах хүчний шингээлттэй, хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж сайтай эдийн засгийн өсөлт бий болгохыг зүй ёсоор шаардаж байна. Энэ нь хүн ам зүйн талаасаа тааламжтай үе боловч тодорхой хугацааны дараа түүний сөрөг үр дагавар хүчтэй илрэх болно. Хүн амд идэр болон ахимаг насны хүн ам зонхилох хувийг эзлэх хандлага 2030-аад оныг хүртэл үргэлжилж, түүнээс цааших хугацаанд насжилт явагдах хэтийн төлөв ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хүн амын насжих явц 20-иод жилийн дараагаас эхлэх бөгөөд үүнтэй холбоотойгоор эрүүл мэнд, нийгмийн хамгааллын болон ахмад настанд үзүүлэх асрамж, халамжийн үйлчилгээний зардал өсөн нэмэгдэж, төсөв багагүй ачаалал үүрэх төлөв ажиглагдаж байна.

Хүүхэд, залуучууд нь хүн амын доторх хамгийн идэвхтэй бөгөөд өөрчлөмтгий хэсэг бөгөөд тэдний тоо, бүтэц, байршил нь хүн амын төрөлт, нас баралт үүний дотор нялхсын болон хүүхдийн нас баралтын үе үеийн түвшин, шилжих хөдөлгөөнтэй нягт уялдаатайгаар өөрчлөгдөж байдаг. Иймээс хүүхэд, залуучуудын тооны өөрчлөлт, гэрлэлт, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж, түүндээ тулгуурлан зарим дүгнэлт, бодлогын чанартай санал дэвшүүлэхэд судалгааны гол зорилго оршино.

Түүнчлэн нийт хүн амын 48.4 хувийг эзэлж буй хүүхэд, залуучуудын ерөнхий дүр төрх, эдийн засгийн идэвх, боловсролын түвшин зэрэгт сүүлийн 10 жилд гарсан өөрчлөлтийг харуулсан судалгааны материал шаардлагатай байгаа бөгөөд судалгаанд хүүхэд, залуучуудын тооны өсөлт, бүтэц, нийт хүн амд эзлэх хувийн жингийн өөрчлөлтийг 2000, 2010 оны тооллогын дүнгээр харуулж XXI зууны нийгмийн хамгийн идэвхтэй хэсгийн талаар баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулахад шаардлагатай суурь материал бэлтгэхийг нэг зорилт болгосон юм. Тоо, бүтцийн өөрчлөлт төдийгүй тэдний сургуульд хамрагдалт, боловсрол, гэрлэлт, эдийн засгийн идэвхийн талаарх мэдээллүүдийг нас, хүйс, байршлаар тусгасан нь хүүхэд, залуучуудын амьдралын тулгамдсан асуудлыг оновчтой шийдвэрлэхэд ач холбогдолтой мэдээлэл болно гэж үзэж байна.

1.2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү сэдэвчилсэн судалгаа нь хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүнд үндэслэн хийгдэж байгаа учир үндсэн ойлголт, тодорхойлолт, хэмжигдэхүүнийг тооллогод ашигласнаар авсан бөгөөд 2000 оны тооллогын мэдээлэлтэй харьцуулагдах байдлыг ч харгалзан үзсэн болно.

Өрхийн тэргүүлэгч. Өрхийн тэргүүлэгч нь 16-аас дээш настай, ажил хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн байна.

Гэрлэлтийн байдал. Өмнө хийгдэж байсан хүн амын тооллогуудад 18 нас хүрсэн залуучуудаас гэрлэлтийн байдлыг асууж байсан бол 2000, 2010 оны улсын тооллогод хүн амын гэр бүлийн байдлыг олон улсын жишигт нийцүүлэн 15 нас хүрсэн залуучуудаас асуусан болно.

- *Огт гэр бүл болоогүй:* Арван тав түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.
- *Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй:* Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг “Батлуулсан гэр бүлтэй”, хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг “Батлуулаагүй гэр бүлтэй” (хамтран амьдрагч) гэж тус тус үзсэн.
- *Тусгаарласан:* Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй, тусдаа амьдарч байгаа хүмүүсийг “тусгаарласан” гэж үзсэн.
- *Цуцалсан:* Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүмүүсийг “цуцалсан” гэж үзсэн.
- *Бэлбэсэн:* Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй бол “бэлбэсэн” гэж үзсэн.

Боловсролын түвшин. Монгол Улсын боловсролын тогтолцооны бүрэлдэхүүнд хамаарах төрөл бүрийн шатны сургууль болон түүнтэй адилтгах сургуулийг гадаадад дүүргэсэн тухайн хүний эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшнээр тодорхойлов.

Эзэмшсэн боловсролын түвшинг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- *Бага боловсрол:*
 - а. Ерөнхий боловсролын 4 дүгээр анги (1975 оныг дуустал хуучин системээр),
 - б. 1975-1996 оныг дуустал 3 дугаар анги,
 - в. 1997-2004 оныг дуустал 4 дүгээр анги,
 - г. 2005 оноос хойш 5 дугаар анги төгсөгчдийг бага боловсролтой хүн амд хамруулсан.
- *Бүрэн бус дунд боловсрол:* Ерөнхий боловсролын сургуулийн 7 дугаар анги (1975 он хүртэл хуучин системээр), 8 дугаар анги төгсөгчдийг бүрэн бус дунд боловсролтой хүн амд хамруулсан.
- *Бүрэн дунд боловсрол:* Ерөнхий боловсролын сургуулийн 10 (11) дүгээр ангийг өдөр, орой, эчнээгээр төгссөн хүнийг бүрэн дунд боловсролтой хүн амд хамруулсан.
- *Техникийн болон мэргэжлийн боловсрол:* Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (Техник мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн мэргэжлийн үнэмлэхтэй хүнийг техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амд хамруулсан.
- *Тусгай мэргэжлийн дунд боловсрол:* Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум) түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амд хамруулсан.

- *Дээд боловсрол (диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш):* Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.
- *Бичиг үсгийн мэдлэг:* Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
- *Сургуульд суралцагчид:* Ямар нэг түвшний боловсрол олгох сургуулийн өдөр, орой, эчнээ ангид тооллогын үед суралцаж байгаа хүмүүсийг сургуульд суралцагчид гэж үзсэн.

Эдийн засгийн идэвх. Тооллогод эдийн засгийн идэвхийг гаргахын тулд богино хугацааны буюу долоо хоногт хамааралтай тухайн үеийн идэвх гэсэн аргыг хэрэглэсэн бөгөөд 15-аас дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг нь тусгасан юм.

- Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн буюу “Тийм-1” гэсэн кодыг дараах нөхцөлд дугуйлсан. Үүнд:
 - Тоолох үеийн өмнөх 7 хоногийн турш эсвэл аль нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн бүх хүн,
 - Ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, өмчийн хэлбэр, тухайн хүний эрхэлж байгаа ажлын зэрэг дэвийг харгалзахгүйгээр ажил эрхэлж байгаа бүх хүн, мөн зах, гудамж талбайд наймаа, худалдаа хийгч, гутал тослогч, сонин борлуулагч, машин угаагч, сийлбэрчин, түүхий эд цуглуулагч зэрэг албан бусаар ажилладаг хүн,
- Тооллогын өмнөх 7 хоногт ажиллаагүй боловч үндсэн байгууллагатайгаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох дараах хүмүүсийг ажил эрхэлсэнд тооцсон. Үүнд:
 - Жирэмсний, хүүхэд төрүүлсний амралт болон 2 хүртэлх настай хүүхдээ асрахаар ажлаас чөлөө авсан,
 - Өвчний болон гэмтсэний улмаас урт, богино хугацааны түр чөлөө авсан,
 - Захиргааны түр чөлөөтэй хүн (цалинтай, цалингүй харгалзахгүй),
 - Ээлжийн амралтаа авсан,
 - Ажил хаялт зарласан,
 - Газар тариалан, алт олборлох, барилга, геологи хайгуул зэрэг улирлын чанартай ажил, үйлдвэрлэл эрхэлдэг учраас өвлийн улиралд түр ажиллахгүй байгаа,
 - Аж ахуйн нэгж, байгууллага нь ямар нэг шалтгаанаар (ажилчид нь ажил хаясан, үйлдвэрлэлийн осол гарсан, байгалийн хүнд нөхцөл, цахилгаан түүхий эд, түлш тасарсан гэх мэт) ажлаа зогсоосон, сургалтад хамрагдсан болон бусад шалтгааны улмаас түр хугацаагаар ажил хийгээгүй хүмүүсийг хамруулна.
- *Ажилгүйчүүд:* Тооллогын өмнөх 7 хоногт цалин, орлоготой ажил эрхлээгүй, тухайн үед ажил хайж байгаа хүмүүсийг ажилгүйчүүдэд оруулсан.

- *Эдийн засгийн идэвхтэй хүн ам:* Ажил эрхэлж байгаа болон ажилгүй байгаа хүн амын нийлбэр.
- *Эдийн засгийн идэвхгүй хүн ам:* Эдийн засгийн идэвхгүй хүн амд тооллогын өмнөх 7 хоногт дараах шалтгааны улмаас ажил эрхлээгүй хүн амыг хамруулав. Үүнд:
 - Сургуульд сурдаг,
 - Тэтгэвэр нөхөн олговорт,
 - Хөдөлмөр эрхлэх чадваргүй,
 - Гэрийн ажилтай,
 - Тохирох ажил олдохгүй байгаа,
 - Ажил хайж байгаа,
 - Ажиллах сонирхолгүй,
 - Бусад

Шилжих хөдөлгөөн. Сэдэвчилсэн судалгаанд шилжих хөдөлгөөнийг тодорхойлохдоо тухайн хүний тооллогын үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг 1 болон 5 жилийн өмнө байнга оршин сууж байсан аймаг, нийслэлтэй зэрэгцүүлж дараах байдлаар тусгав.

- Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөнд тухайн хүн 2005 оны 1 дүгээр сарын 1-нд тооллогын үед байнга оршин сууж байгаа аймаг, нийслэлээсээ өөр аймаг, нийслэлд амьдарч байсан бол 5 жилийн шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзэв.
- Нэг жилийн шилжих хөдөлгөөнд тухайн хүн нэг жилийн өмнө буюу 2009 оны эхэнд тооллогын үед байнга оршин сууж байгаа аймаг, нийслэлээсээ өөр аймаг, нийслэлд амьдарч байсан бол 1 жилийн шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзлээ.

Хөгжлийн бэрхшээл. “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно”¹

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- **Төрөлхийн** хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ.
- Хөгжлийн **олдмол** бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- *Харааны:* Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
- *Ярианы:* Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
- *Сонсголын:* Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.

¹ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 3-р зүйл

- **Хөдөлгөөний:** Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
- **Сэтгэцийн:** Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцооны дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан оюун ухааны бэрхшээлийг сэтгэцийн эмгэг гэж ойлгоно.
- **Бусад:** Хөгжлийн бэрхшээлийн дээр дурьдсан хэлбэрээс бусад хэлбэрийг үүнд хамааруулна. Тухайлбал, дотор эрхтний өвчин эмгэг болон хоёр ба түүнээс дээш хөгжлийн бэрхшээл нэг хүнд хамт илэрч байвал бусдад хамааруулна.


1.3. СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү судалгаа нь удиртгал, хавсралтуудыг оролцуулан нийт 8 бүлгээс бүрдэж байгаа бөгөөд 2 дугаар бүлэгт хүүхэд, залуучуудын тоо, нас, хүйсийн бүтцийн өөрчлөлт, үндэс угсаа, шашин шүтлэг, орон сууцны нөхцөлийн талаарх ерөнхий дүр төрхийг, 3 дугаар бүлэгт хүүхдийн сургуульд хамрагдалт, шилжих хөдөлгөөн, гар утас, интернетийн хэрэглээг нас хүйс, хот, хөдөөгөөр ялган харуулснаас гадна хүүхдийн эрүүл мэндийн байдлыг төрөлхийн болон олдмол хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг төрлөөр илэрхийлэхийг зорив.

Судалгааны 4 дүгээр бүлэгт залуучуудын гэрлэлтийн байдал, шилжих хөдөлгөөн, боловсрол, гар утас, интернетийн хэрэглээний байдлыг авч үзэв. Мөн залуучуудын эрүүл мэндийн байдлыг төрөлхийн болон олдмол хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг төрлөөр гаргаж харууллаа. 5 дугаар бүлэгт залуучуудын эдийн засгийн идэвхийг авч үзсэн бол 6 дугаар бүлэгт хүүхэд, залуучуудын дүр төрхийн бүс нутаг, аймаг хоорондын ялгаатай байдлыг харуулахыг зорив. Судалгааны 7-р бүлэгт хүүхэд, залуучуудын тоо, нас, хүйсийн бүтэц, боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн идэвхийн байдалд гарсан өөрчлөлтүүдийг дүгнэж, бодлогын зөвлөмж, саналуудыг тусгалаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЕРӨНХИЙ ТӨРХ




Хүүхэд, залуучуудын нийгэм, эдийн засгийн байдал тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, эрхийн хэрэгжилт, амьдарч буй орчин нөхцөл зэрэг нь хүний хөгжлийн үндэс төдийгүй хүүхэд насандаа эрүүл саруул өссөнөөр боловсрол эзэмшиж, цаашлаад насанд хүрч ажил хөдөлмөр эрхлэх зэрэгт суурь болж өгдөг. Тиймээс бид энэ судалгаандаа хүүхэд, залуучуудын нас, хүйсийн бүтэц, үндэс угсаа, боловсрол, эрүүл мэнд, залуучуудын хувьд шашин шүтлэг, хөдөлмөр эрхлэлт зэргийг нарийвчлан авч үзлээ.

2.1. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ХОТ, ХӨДӨӨГИЙН ЯЛГАА

Нас, хүйс гэсэн үзүүлэлтийг 2010 оны тооллогоор төрсөн огноо, түүнд үндэслэн тооллогын товтой харьцуулсан бүтэн нас, эрэгтэй, эмэгтэй гэсэн үндсэн хоёр ангилалд багтах хүйсийн уламжлалт ойлголтоор тодорхойлон авч үзсэн юм.


Тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын бууралт гэдэг бөгөөд хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 0-24 насны 1332.3 мянган хүүхэд, залуучууд тоологдсон нь 1956 оны тооллогын дүнгээс 3.3 дахин, 1963 оны тооллогынхоос 2.4 дахин их байгаа бөгөөд энэ нь 1989 оны тооллогын дүнгээс 4.6 хувиар өсч, 2000 оны тооллогынхоос 1.2 хувиар буурчээ. Түүнчлэн хүүхэд, залуучуудын тооны тооллого хоорондын өсөлтийг авч үзвэл 1956-1963 оны тооллогын хооронд хамгийн өндөр буюу 7.8 хувиар өссөн байна. Хүн ам, орон сууцны 1979 оны тооллогоор 0-24 насны 1020.8 мянган хүүхэд, залуучууд тоологдсон нь 1969 оныхоос 327.1 мянган хүнээр өссөн нь жилд дунджаар 32.7 мянгаар нэмэгдсэн үр дүн төдийгүй 1956 оноос 2010 оны хооронд хамгийн өндөр өсөлт болж байгаа юм.

ЗУРАГ 2.1. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, ТООЛЛОГО ХООРОНДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ




Дэлхийн 2-р дайны дараагаар ихэнх хөгжиж байгаа улс оронд төрөлт нэмэгдэж нийт хүн амд эзлэх хүүхэд, залуучуудын хувь нэлээдгүй хэмжээгээр өссөн. Энэ хандлага манай улсад ч ажиглагдсан бөгөөд өнгөрсөн зууны тавиад оны сүүлч, жараад оны эхэн үед төрөлтийн тоо эрс нэмэгдэж, улмаар хүн ам залуужих үйл явц эхэлсэн юм. Хүн амын залуужих үйл явц нь 2 мөчлөгтэй байсан бөгөөд эхний мөчлөгийн үед хүүхдийн тооны өсөлт их, хоёр дахь мөчлөгт залуучуудын тооны өсөлт хүүхдийнхээс давсан байна. Тухайлбал, 1956-1963 оны хооронд 0-14 насны хүүхдийн тоо 7.8 хувиар өсч 15-24 насны залуучуудын тоо 0.2 хувиар буурч байсан бол үүнээс хойших тооллого хооронд 15-24 насны залуучуудын тооны өсөлт 0-14 насны хүүхдүүдийнхээс давсан байна. 2000-2010 оны хооронд 0-14 насны хүүхдийн тоо 1.1 хувиар буурсан бол 15-24 насны залуучуудын тоо 1.6 хувиар өсчээ.

ЗУРАГ 2.2. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТООНЫ ТООЛЛОГО ХООРОНДЫН ӨСӨЛТ, ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Нийт хүн амын дунд 0-15 насны хүн амын эзлэх хувь 35 ба түүнээс дээш бол тухайн улсыг залуу хүн амтай улс гэж үздэг. Манай улсын нийт хүн амд 15 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь 1956-1969 онуудад 30.4-44.5 байсан бол 1979 оноос буурсаар 2010 онд 28.0 хувь болсон байна. Харин нийт хүн амд эзлэх залуучуудын хувь 1963-1969 онуудад 13.5-14.0 байсан бол 1969-1979 онд огцом өсч (6.2 пунктээр) түүнээс хойш аажмаар нэмэгдсэн ч 2010 онд яльгүй буурч 20.8-д хүрсэн байна.

ЗУРАГ 2.3. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР




Нийт хүн амд 0-24 насны хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жин 2010 онд 48.7 хувь болсон нь өмнөх 2 тооллогынхоос буурсан байна. Харин 0-4 насны хүүхдийн эзлэх хувь бага зэрэг өссөн нь 2006-2009 онуудад төрөлт нэмэгдсэнтэй холбоотой юм.

ХҮСНЭГТ 2.1. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 1989, 2000, 2010 ОН

Насны бүлэг	1989			2000			2010		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	62.9	61.7	62.3	57.7	55.9	56.8	49.8	47.8	48.7
0-4	16.1	15.7	15.9	10.6	10.2	10.4	11.2	10.6	10.9
5-9	13.6	13.3	13.5	12.3	11.8	12.0	8.4	8.0	8.2
10-14	12.6	12.4	12.5	13.5	13.2	13.4	9.1	8.8	8.9
15-19	11.0	10.7	10.8	11.3	10.9	11.1	9.9	9.5	9.7
20-24	9.6	9.6	9.6	10.0	9.8	9.9	11.2	10.9	11.0
ХОТ - БҮГД	61.2	60.9	61.0	55.4	53.9	54.8	50.0	47.6	48.7
0-4	15.2	14.6	14.9	8.9	8.3	8.6	11.0	10.1	10.5
5-9	12.8	12.4	12.6	11.5	10.9	11.2	7.8	7.1	7.4
10-14	11.8	11.6	11.7	13.6	13.1	13.4	8.3	7.7	8.0
15-19	11.5	11.9	11.7	11.4	11.5	11.5	10.6	10.4	10.5
20-24	9.9	10.4	10.1	10.0	10.1	10.1	12.3	12.3	12.3
ХӨДӨӨ - БҮГД	65.1	62.7	64.0	60.5	58.7	59.5	49.5	48.0	48.9
0-4	17.2	17.2	17.2	12.7	12.7	12.7	11.5	11.9	11.7
5-9	14.7	14.5	14.6	13.2	13.1	13.1	9.5	9.9	9.7
10-14	13.7	13.5	13.6	13.4	13.4	13.4	10.8	11.1	11.0
15-19	10.4	8.9	9.7	11.2	10.0	10.6	8.7	7.6	8.2
20-24	9.1	8.6	8.9	10.0	9.5	9.7	9.0	7.5	8.3


Хүйсийн харьцааг 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлдэг бөгөөд хүүхэд, залуучуудын хүйсийн харьцааг авч үзэхэд 15 хүртэлх насны 100 охинд 103 хүү, 15-24 насны 100 залуу эмэгтэйд 102 залуу эрэгтэй ногдож байна. Олон улсын жишгээр 100 охин төрөхөд 104-106 хүү төрж, цаашдаа хүйсийн энэ харьцаа жигдэрсээр нас ахих тусам эмэгтэйчүүд нь давамгайлж, хүйсийн харьцаа буурдаг зүй тогтол манайд ч ажиглагдаж байна.

ЗУРАГ 2.4. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН




Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 15 хүртэлх насны нийт хүүхдийн 62.9 хувь, 15-24 насны залуучуудын 74.6 хувь нь хотод амьдарч байна. Хүүхэд, залуучуудын нас, хүйсийн бүтцэд гарсан нэг өөрчлөлт бол 2010 онд хөдөөд тоологдсон 15-24 насны залуучуудын тоо багасч, хотод амьдарч буй залуучуудын тоо нэмэгдсэн явдал юм.

ЗУРАГ 2.5. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН



Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 0-24 насны хүүхэд, залуучуудын 44.0 хувь нь нийслэлд, 21.0 хувь нь аймгийн төвд оршин сууж байна. Энэ байдалд хүн амын дотоод шилжих хөдөлгөөн нөлөөлж байгаа бөгөөд залуучуудын төв суурин газарт боловсрол эзэмших, хот, суурин газарт амьдрах гэсэн хүсэлтэй холбоотой байж болох юм.

ЗУРАГ 2.6. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, БАЙРШЛААР, 2010 ОН



Хот, аймгийн төвд амьдарч буй хүүхэд, залуучуудын дотор эмэгтэйчүүд илүү, харин тосгон, сумын төв, хөдөөд эрэгтэйчүүд илүү байна. Тухайлбал, нийслэлд амьдарч буй 0-24 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 4.8 мянгаар илүү байгаа юм.

ХҮСНЭГТ 2.2. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, БАЙРШЛААР, 2010 ОН

Насны бүлэг	Байршил					
	Бүгд	Нийслэл	Аймгийн төв	Тосгон	Сумын төв	Хөдөө
ХҮН АМ - БҮГД	1 291 404	563 092	278 211	35 283	171 883	242 935
0-4	288 497	119 637	60 781	8 464	39 079	60 536
5-9	216 214	80 040	47 203	6 497	34 299	48 175
10-14	236 865	82 753	53 822	7 271	39 332	53 687
15-19	257 645	121 019	61 144	6 171	30 466	38 845
20-24	292 183	159 643	55 261	6 880	28 707	41 692
ЭРЭГТЭЙ - БҮГД	654 729	279 153	138 492	18 264	90 239	128 581
0-4	146 516	60 587	30 799	4 285	19 870	30 975
5-9	110 117	40 885	23 923	3 311	17 356	24 642
10-14	120 064	41 840	26 721	3 683	19 936	27 884
15-19	130 560	58 632	30 187	3 305	17 122	21 314
20-24	147 472	77 209	26 862	3 680	15 955	23 766
ЭМЭГТЭЙ - БҮГД	636 675	283 939	139 719	17 019	81 644	114 354
0-4	141 981	59 050	29 982	4 179	19 209	29 561
5-9	106 097	39 155	23 280	3 186	16 943	23 533
10-14	116 801	40 913	27 101	3 588	19 396	25 803
15-19	127 085	62 387	30 957	2 866	13 344	17 531
20-24	144 711	82 434	28 399	3 200	12 752	17 926

2.2. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС УГСАА


2.2.1. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ

Монгол Улсын Үндсэн хуулиар эрх зүйн байдал нь хуульчлагдаж, Монгол Улсын бүрэн эрхт байдлыг төлөөлөн бүх талын эрх зүйн харилцаанд ордог хүнийг Монгол Улсын иргэн гэнэ. Монгол Улсад хүнийг төрөлх чанар, угаас заяасан эрх, эрх чөлөө, улс төр, хууль зүйн түгээмэл утгаар нь иргэн, төртэй харьцах эрх зүйн тодорхой харьцаанд ордог утгаар нь харьяат гэж нэрлэдэг².

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн 5 дугаар зүйлд “гадаадын иргэн” гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг, “харьяалалгүй хүн” гэж аль ч улсын харьяат бус хүнийг хэлнэ гэж заажээ.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр манай улсад байнга оршин сууж буй 15 хүртэлх насны хүүхдийн 99.8 хувь, 15-24 насны залуучуудын 99.6 хувь нь Монгол Улсын харьяат, харин хүүхдүүдийн 0.2 хувь, залуучуудын 0.4 хувь нь гадаадын харьяат байна. Гадаадын харьяат хүүхэд, залуучуудын 59.1 хувь нь эрэгтэй, 45.7 хувь нь 20-24 насныхан байна.

ЗУРАГ 2.7. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛААР, 2010 ОН




Аль нэг улсын харьяалалгүй 27 хүүхэд, залуучууд тоологдсоны 48.1 хувь нь 0-4 насны хүүхдүүд байв. Мөн харьяалалгүй хүүхдүүдийн 51.9 хувь нь охид байгаа юм.

Монгол Улсад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын харьяат 0-24 насны 3.3 мянган хүүхэд, залуучуудыг улсаар нь авч үзвэл, 58.0 хувь нь БНХАУ, ОХУ-ын харьяат, 14.0 хувь нь БНСУ-ын харьяат байна.

² Ж. Амарсанаа, Г. Совд, бусад: “Хууль зүйн тайлбар толь”, Улаанбаатар, 2003

ЗУРАГ 2.8. ГАДААДЫН ХАРЬЯАТ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, УЛСААР, ХУВИАР, 2010 ОН



2.2.2. ҮНДЭС УГСАА

Үндэс угсаа гэдэг нь тухайн үндэстнийг бүрдүүлэгч газар нутаг, иргэншлийн хувьд нэгдмэл байх нийтлэг өв соёлтой, хэл, шашин шүтлэг, ертөнцийг үзэх нийтлэг үзэлтэй, үүсэл гарвал нэгтэй омог ястнуудыг ерөнхийд нь нэрлэсэн ойлголт юм.

Хүн ам, орон сууцны тооллогоор тухайн улсын харьяат иргэдийн үндэс угсааны талаарх мэдээллийг цуглуулдаг бөгөөд манай улсын хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 15 хүртэлх насны хүүхдийн 81.2 хувь нь халх, 4.9 хувь нь казак, 2.9 хувь нь дөрвөд, 2.3 хувь нь баяд, 1.5 хувь нь буриад, 1.4 хувь нь захчин, 1.0 хувь нь дарьганга, 1.0 хувь нь урианхай, 0.9 хувь нь дархад байв. Харин 15-24 насны залуучуудын хувьд 83.0 хувь нь халх, 3.9 хувь нь казак, үлдсэн хувь нь дөрвөд, баяд, буриад, захчин, урианхай, дарьганга ястан байна.

ХҮСНЭГТ 2.3. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ҮНДЭС УГСААГААР, 2000, 2010 ОН

Үндэс угсаа	2000				2010			
	0-14 насны хүүхэд		15-24 насны залуучууд		0-14 насны хүүхэд		15-24 насны залуучууд	
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь
МОНГОЛЫН ХАРЬЯАТ-БУГД	847 706	100.0	497 987	100.0	740 267	100.0	547 814	100.0
Халх	686 386	81.0	411 116	82.6	600 894	81.2	454 760	83.0
Казак	43 805	5.2	21 169	4.3	36 064	4.9	21 146	3.9
Дөрвөд	24 554	2.9	13 344	2.7	21 400	2.9	15 036	2.7
Баяд	18 833	2.2	10 021	2.0	16 764	2.3	11 528	2.1
Буриад	12 416	1.5	7 986	1.6	11 005	1.5	8 620	1.6
Захчин	11 412	1.3	6 081	1.2	10 017	1.4	6 812	1.2
Дарьганга	10 899	1.3	6 541	1.3	7 193	1.0	4 689	0.9
Урианхай	8 949	1.1	5 115	1.0	7 607	1.0	5 285	1.0
Дархад	7 164	0.8	3 663	0.7	6 484	0.9	4 455	0.8
Хотгойд	2 514	0.3	1 557	0.3	4 586	0.6	2 802	0.5
Хотон	4 010	0.5	1 825	0.4	4 299	0.6	2 397	0.4
Торгууд	4 487	0.5	2 459	0.5	3 844	0.5	2 822	0.5
Өөлд	5 171	0.6	2 964	0.6	3 915	0.5	3 099	0.6
Мянгад	2 205	0.3	1 324	0.3	1 884	0.3	1 307	0.2
Тува	1 820	0.2	961	0.2	1 611	0.2	1 062	0.2
Барга	824	0.1	536	0.1	669	0.1	622	0.1
Үзэмчин	801	0.1	488	0.1	697	0.1	519	0.1
Элжигэн	48	0.0	27	0.0	445	0.1	200	0.0
Сартуул	553	0.1	315	0.1	262	0.0	239	0.0
Хамниган	207	0.0	102	0.0	124	0.0	75	0.0
Бусад үндэстэн	648	0.1	393	0.1	503	0.1	339	0.1

Манай улсын нийт хүн амын дунд эзлэх казакуудын хувийн жин өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд 0.5 пунктээр буурсныг дагаад нийт хүүхэд, залуучуудын дунд эзлэх казакуудын хувийн жин буурсан ба нийт казак иргэдийн дунд 15 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувийн жин ч 2000 онтой харьцуулахад буурсан байгаа боловч бусад үндэс угсаатай харьцуулахад энэ үзүүлэлт өндөр хэвээр байна.


Хүүхэд, залуучуудын хүйсийн харьцааг үндэс угсаагаар авч үзвэл, эрэгтэйчүүд дийлэнх байгаа нь шинээр төрж буй хүүхдүүдийн дотор хөвгүүд олон байгаад цаашдаа хүйсийн энэ харьцаа жигдэрсээр нас ахих тусам эмэгтэйчүүд нь давамгайлж, хүйсийн харьцаа буурдаг зүй тогтол мөн ажиглагдаж байна. Энэ зүй тогтол 2000 оны тооллогын дүнгээс ч мөн харагдаж байлаа. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт нь урианхай, хотон охидын тоо хөвгүүдээс илүү, торгууд, тува залуучуудын дотор эмэгтэйчүүд илүү болсон байна.

ХҮСНЭГТ 2.4. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ҮНДЭС УГСААГААР, 2000, 2010 ОН

	2000				Хүйсийн харьцаа		2010				Хүйсийн харьцаа	
	0-14		15-24		0-14	15-24	0-14		15-24		0-14	15-24
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй		
Халх	345 817	340 569	206 263	204 853	101.5	100.7	305 214	295 680	229 335	225 425	103.2	101.7
Казак	22 227	21 578	10 645	10 524	103.0	101.1	18 251	17 813	10 678	10 468	102.5	102.0
Дөрвөд	12 371	12 183	6 914	6 430	101.5	107.5	10 930	10 470	7 604	7 432	104.4	102.3
Баяд	9 596	9 237	5 246	4 775	103.9	109.9	8 632	8 132	5 913	5 615	106.1	105.3
Буриад	6 269	6 147	4 076	3 910	102.0	104.2	5 540	5 465	4 449	4 171	101.4	106.7
Дарьганга	5 581	5 318	3 459	3 082	104.9	112.2	3 688	3 505	2 482	2 207	105.2	112.5
Захчин	5 768	5 644	3 110	2 971	102.2	104.7	5 086	4 931	3 469	3 343	103.1	103.8
Урианхай	4 511	4 438	2 627	2 488	101.6	105.6	3 795	3 812	2 700	2 585	99.6	104.4
Дархад	3 544	3 620	1 869	1 794	97.9	104.2	3 270	3 214	2 234	2 221	101.7	100.6
Өөлд	2 646	2 525	1 531	1 433	104.8	106.8	2 013	1 902	1 566	1 533	105.8	102.2
Торгууд	2 226	2 261	1 236	1 223	98.5	101.1	1 939	1 905	1 403	1 419	101.8	98.9
Хотон	2 064	1 946	868	957	106.1	90.7	2 145	2 154	1 234	1 163	99.6	106.1
Хотгойд	1 285	1 229	796	761	104.6	104.6	2 325	2 261	1 483	1 319	102.8	112.4
Мянгад	1 100	1 105	670	654	99.5	102.4	944	940	657	650	100.4	101.1
Тува	856	964	484	477	88.8	101.5	822	789	525	537	104.2	97.8
Бусад	1 521	1 560	955	906	97.5	105.4	1 418	1 282	1 024	970	110.6	105.6
Бусад үндэстэн	709	706	601	521	100.4	115.4	674	612	1 274	736	110.1	173.1

Казак, Дарьганга, Захчин, Дархад, Хотгойд, Элжигэн, Цаатан, Тува зэрэг угсаатан хүүхэд, залуучуудын дийлэнх нь хөдөө суурьшиж байна /Зураг 2.9/.

ЗУРАГ 2.9. 0-24 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД ТОО, ҮНДЭС УГСАА, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



2.3. ЗАЛУУЧУУДЫН ШАШИН ШҮТЛЭГ

Шашин шүтлэг нь хүн төрөлхтөн үүсэж оршин тогтносон цагаасаа өөрсдийн амьдралд бий болгосон дэлхий дахины нийтлэг үзэгдэл юм. Энэ нь хүний амьдралын сонголт, арга барил, соёлын үзэл ухагдахуунд нөлөөлдөг соёл, нийгмийн үндсэн тал мөн. Шашин шүтлэг нь сорилт, эргэлзэж тээнэгэлзсэн байдлаас холдуулж зайлсхийлгэж чадахгүй ч гэлээ залуучуудын соёлд онцгой нөлөө үзүүлж, чухал байр суурь эзэлсэн хэвээр байна³.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар /1992 оны/ иргэд шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй болсноор төрөл бүрийн урсгалын сүм хийд олноор байгуулагдаж эхэлсэн юм. Уламжлалт буддын шашны сүм хийд олноор байгуулагдаж байгаагийн зэрэгцээ христийн болон бусад шашны сүм хийд, шашны байгууллагуудын тоо нэмэгдэж байна. Манай улсын албан ёсны статистикийн мэдээллээр, сүм хийдийн тоо 2010 онд 234 болж 2009 оныхоос 0.9 хувиар өсчээ. Шашны сургууль, дацанд суралцагчид 2010 онд 1.6 мянга болж өмнөх оныхоос 22.9 хувиар, гэрээр шашны ном заалгадаг хүүхдийн тоо 4.5 мянга болж 9.2 хувиар өсөв. Нийт сүм хийдийн 54.3 хувийг будда, 41.0 хувийг христ, 2.6 хувийг ислам, 2.1 хувийг бусад шашны сүм хийд эзэлж байна⁴.


Өмнөх тооллогод шашин шүтлэгийн талаар асууж байгаагүй бөгөөд 2010 оны тооллогоор 15 ба түүнээс дээш насны хүн амаас шашин шүтдэг эсэх, шүтдэг бол ямар шашин шүтдэгийг асуусан юм.

³ UNFPA: "Adolescence education", Volume 9, 2006

⁴ УСХ: "Нийгмийн статистик 2010" танилцуулга 49-р хуудас

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 15-24 насны 549.8 мянган залуучууд тоологдсоны 46.1 хувь нь ямар нэг шашин шүтдэггүй, 53.9 хувь нь шашин шүтдэг гэж хариулжээ. Арван таван настай хүүхдүүдийн хувьд шашин шүтдэггүй хүүхдийн тоо олон байгаа ч нас ахих тусам шашин шүтэгчдийн тоо нэмэгдэж байна.


ЗУРАГ 2.10. ЗАЛУУЧУУДЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, НАС, ХҮЙСЭЭР, 2010 ОН



15-24 насны шашин шүтдэг залуучуудын 82.0 хувь нь буддын шашин, 18.0 хувь нь христ, ислам, бөө болон бусад шашин шүтдэг байна.


15-17 насныхны дунд уламжлалт буддын шашнаа шүтдэг эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо ижил байгаа ч нас ахих тусам буддын шашин шүтдэг эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байна.

ЗУРАГ 2.11. БУДДЫН ШАШИН ШҮТДЭГ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАС, ХҮЙСЭЭР, 2010 ОН




Ислам шашин шүтдэг залуучуудын дунд эрэгтэйчүүд илүү байгаа бол бусад шашны хувьд эмэгтэйчүүд илүү байна.

ЗУРАГ 2.12. ШАШИН ШҮТДЭГ ЗАЛУУЧУУД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ШАШНЫ УРСГАЛААР, 2010 ОН




Залуучуудын шашин шүтлэгийн байдал хот, хөдөөгөөр ялгаатай байгаа бөгөөд хөдөө амьдарч байгаа шашин шүтдэг залуучууд аль ч насны хувьд хотынхоос илүү байна.

ЗУРАГ 2.13. ШАШИН ШҮТДЭГ ЗАЛУУЧУУД, НАС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



Шашны урсгалаар нь судлахад буддын шашин шүтдэг 15-24 насны залуучуудын эзлэх хувь хот, хөдөөд ижил, харин христийн шашин шүтдэг хотын залуучууд хөдөөгийнхөөс 3 дахин их, исламын шашин шүтдэг залуучуудын хувьд хөдөөд хотынхоос 3 дахин их байна.

ЗУРАГ 2.14. ШАШИН ШҮТДЭГ ЗАЛУУЧУУД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨ, ШАШНЫ УРСГАЛААР, 2010 ОН




Ислам шашны хувьд хөдөөгийн залуучуудын 6.5 хувь нь шүтэж байгаа нь хотынхоос 3 дахин их байгаа бөгөөд ислам шашинтнуудын дийлэнх нь казак үндэстэн юм.

2.4. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр манай улсын 0-18 насны хүүхэдтэй өрхийн 80 гаруй хувь нь 0-15 насны хүүхэдтэй өрх байгаа бөгөөд өрхөд тоологдсон хүүхдүүдийн мөн 85 хувь нь 0-15 насны хүүхэд байна /Зураг 2.15/.

ЗУРАГ 2.15. 0-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮҮХДИЙН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН




2010 оны тооллогод 0-15 насны хүүхэдтэй 573.3 мянган өрх тоологдсон нь өмнөх тооллогынхоос 38.3 хувиар нэмэгджээ.

0-15 насны хүүхэдтэй өрхийн 46.8 хувь нь гэрт, 52.4 хувь нь байшинд, 0.8 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байгаа бөгөөд өрхөд тоологдсон хүүхдүүдийн 48.9 хувь нь гэрт, 50.3 хувь нь байшинд, 0.8 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.


Манай улсын харьяат 0-18 насны хүүхэд, залуучуудын 47.3 хувь нь буюу 10 хүүхэд тутмын 5 нь, хүүхэдтэй нийт өрхөд тоологдсон энэ насны 10 хүүхэд тутмын 5 нь гэрт амьдарч байна.

ЗУРАГ 2.16. 0-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮҮХДИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010 ОН




2010 оны тооллогод тоологдсон 0-18 насны 10 хүүхэд тутмын 5 нь, өрхөд тоологдсон 10 хүүхэд тутмын 9 нь байшинд амьдарч байна. Байшинд амьдардаг өрхийн 57.8 хувь нь сууцны тусдаа байшинд, 37.5 хувь нь орон сууцны байшинд амьдарч байна.

ЗУРАГ 2.17. БАЙШИНД АМЬДАРДАГ 0-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХИЙН ТОО, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮҮХДИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН




0-18 насны хүүхэдтэй өрхүүдийн 22.0 хувь нь төвлөрсөн системээс, 20.0 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас, 22.0 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас ундны усаа авч хэрэглэдэг байна.

ЗУРАГ 2.18. 0-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХИЙН ТОО, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, 2010 ОН




Зөөврийн ус хэрэглэдэг өрхөд тоологдсон 10 хүүхэд тутмын 5 нь 200 метр хүртэл зайнаас, 4 нь 200-1000 метр, 1 нь 1000 метрээс дээш зайнаас ус зөөдөг байна. Ус зөөдөг хүүхдүүдийн 45.9 хувь нь 7-15 насны хүүхдүүд байна.

ЗУРАГ 2.19. 0-18 НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ҮНДНҮЙ УСАА АВДАГ ЗАЙГААР, 2010 ОН




Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 0-18 насны хүүхэдтэй өрхийн 97.3 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, үлдсэн 2.7 хувь нь ямар нэг цахилгааны эх үүсвэргүй байна. Хүүхэдтэй өрхөд тоологдсон 5 хүүхэд тутмын 1 нь цахилгааны эх үүсвэргүй өрхөд амьдарч байна.

ЗУРАГ 2.20. 0-18 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХИЙН ТОО, ХҮҮХДИЙН НАСНЫ БҮЛЭГ, ХООЛ УНДАА ИХЭВЧЛЭН БОЛГОДОГ ТҮЛШНИЙ ТӨРЛӨӨР, ХУВИАР, 2010 ОН




Өрх тэргүүлэн амьдардаг 15-24 насны 52.4 мянган залуучуудын 68.4 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 18.3 хувь нь бусдын сууцыг түрээсэлж амьдарч байна. Өрхийн тэргүүлэгч залуу эрэгтэйчүүдийн 71.9 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 15.6 хувь нь бусдын сууцыг түрээсэлж амьдардаг бол залуу эмэгтэйчүүдийн 54.5 хувь өөрийн эзэмшлийн сууцанд, 28.7 хувь бусдын сууцыг түрээсэлж амьдарч байна.

ЗУРАГ 2.21. ӨРХ ТЭРГҮҮЛЭН АМЬДАРЧ БАЙГАА 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, ХҮЙС, СУУЦНЫ ЭЗЭМШЛЭЭР, 2010 ОН



15-24 насны залуучуудын дийлэнх нь өөрийн эзэмшлийн гэрт амьдарч байна.

ЗУРАГ 2.22. ӨРХ ТЭРГҮҮЛЭН АМЬДАРЧ БАЙГАА 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ЭЗЭМШЛЭЭР, 2010 ОН



Хөдөөгийн залуучуудын 69.5 хувь нь өөрийн эзэмшлийн гэрт амьдардаг бол хотод тоологдсон залуучуудын 31.3 хувь нь өөрийн эзэмшлийн гэрт, 32.0 хувь нь өөрийн эзэмшлийн байшинд амьдарч байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХҮҮХЭД




Аливаа улс орны хөгжил дэвшлийн суурь нь хүний хөгжил бөгөөд хүний хөгжил нь хүүхдийн хөгжлөөс эхлэлтэй юм. Хүүхэд эрүүл өсч, торнин, мэдлэг, боловсрол эзэмшиж зөв төлөвших нь нийгэмд эзлэх байр суурь, хувь хүнийг тодорхойлох үндсэн хүчин зүйлүүдийн нэг болдог.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Хүүхдийн эрхийн конвенци”-д Монгол Улс нэгдсэн орсныхоо хувьд хүүхдийг ямар нэгэн ялгаварлалгүй, эсэн мэнд амьдрах, эрүүл саруул өсөн торних, бүхий л талаараа хөгжих, үнэ төлбөргүй суурь боловсрол эзэмших, олон эх сурвалжаас мэдээлэл авах, сүсэглэх, шашин шүтэх зэрэг олон эрхийн хэрэгжилтийг хангаж, түүнд чиглэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, түүнчлэн хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тоо мэдээллүүдийг гаргаж байх үүрэг хүлээдэг юм. Тэр ч утгаараа Улсын Их Хурлаас 1996 онд “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг баталснаас гадна Засгийн газрын зүгээс 2002 онд “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2003-2010)”-ийг хэрэгжүүлсэн байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 0-14 насны 741.6 мянган хүүхэд тоологдсоны 376.7 мянга нь эрэгтэй, 364.9 мянга нь эмэгтэй, хүйсийн харьцаа 103 байв. Энэ насны нийт хүүхдийн 62.9 хувь нь хотод, 37.1 хувь нь хөдөөд амьдардаг байна.

Хүүхдийн эрхийн конвенц болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар 18 хүртэлх насны бүх хүнийг хүүхэд гэж үздэг бөгөөд хүүхдийн тоо 2010 оны тооллогын дүнгээр 888.0 мянга байгаагаас 450.9 мянга нь эрэгтэй, 437.1 мянга нь эмэгтэй байгаа юм.

ЗУРАГ 3.1. 0-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



3.1. СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

2010 оны тооллогоор 6 ба түүнээс дээш насны хүн бүрээс боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, 2-39 насны хүн амаас аль нэг шатны сургуульд суралцаж байгаа эсэхийг асуусан болно.


Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогоор боловсрол, бичиг үсгийн мэдлэгийг хоёр салангид асуултаар асууж, ингэснээр багаас доош боловсролтой хүмүүсийг бичиг үсэг мэддэг, үл мэддэг болохыг тодруулсан юм.

3.1.1. БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Ямар нэг боловсрол эзэмшээгүй ч аль нэг хэлээр хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичих чадвартай хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзнэ.


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 6-14 насны 409.7 мянган хүүхэд тоологдсоны 247.0 мянган хүүхэд буюу 60.3 хувь нь боловсролгүй байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 90.5 хувь нь боловсролгүй ч бичиг үсэг мэддэг байна.

ЗУРАГ 3.2. 6-14 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, 2010 ОН




6-14 насны хүүхдүүдийн дотор бичиг мэддэг хөвгүүд охидоосоо 4.9 мянгаар, бичиг үсэг мэддэггүй хөвгүүд охидоосоо мөн 1.7 мянгаар илүү байгаа нь 15 хүртэл насны хүүхдүүд түүний дотор 6-14 насны хөвгүүдийн тоо охидоосоо илүү байгаагаас хамаарч байж болох юм.

ЗУРАГ 3.3. 6-14 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2010 ОН



6-11 насны бичиг үсэг мэддэг хүүхдийн тоо хотод илүү, харин 12-14 насны хувьд хөдөөд бага зэрэг илүү байна. Хотын 6-9 насны бичиг үсэг мэддэггүй хүүхдийн тоо хөдөөгийнхөөс илүү байгаа ч 10-14 насанд хөдөөгийнх илүү байгаа нь энэ насны хүүхдүүдийн сургууль завсардалт хөдөөд илүү байдагтай холбоотой байж болох юм. Бичиг үсэг мэддэг хүүхдүүдийн 66.5 хувь, мэддэггүй хүүхдүүдийн 86.0 хувь нь 6-14 насныхан байна.

ЗУРАГ 3.4. 6-14 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХОТ, ХӨДӨӨ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2010 ОН



3.1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ (СӨБ) БОЛОН БҮХ ШАТНЫ СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 1989, 2000 оны тооллогоор 7-29 насны хүн бүрээс сургуульд суралцаж байгаа эсэхийг асууж байсан бол 2010 онд сургуульд суралцаж байгаа эсэхийг тодорхойлохдоо 2-5 насны хүүхдээс цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг, 6-39 насны хүнээс албан ёсны боловсрол олгох сургуульд суралцаж байгаа эсэхийг асуусан болно.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 2-39 насны 1834.9 мянган хүн тоологдсоны 45.6 хувь нь цэцэрлэг, сургуульд хамрагддаг, 54.4 хувь нь аль нэг шатны сургуульд хамрагддаггүй байна.

СӨБ-Д ХАМРАГДАЛТ

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулинд сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь цэцэрлэг болохыг заасан бөгөөд ҮСХ-оос гаргасан албан ёсны статистикийн мэдээллээр 2010/2011 оны хичээлийн жилд нийт 839 цэцэрлэг⁵ ажиллаж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 2-5 насны 202.4 мянган хүүхэд тоологдсоны 60.1 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа бол үлдсэн 39.9 хувь нь цэцэрлэгт хүмүүждэггүй хүүхдүүд байна. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа 2-5 насны хүүхдүүдийн 50.1 хувь нь хөвгүүд, 49.9 хувь нь охид байв /Хүснэгт 3.1/.

ХҮСНЭГТ 3.1. 2-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГ ЭСЭХЭЭР, 2010 ОН

Нас	Бүгд			Цэцэрлэгт хүмүүждэг			Цэцэрлэгт хүмүүждэггүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	202 420	102 986	99 434	121 647	60 910	60 737	80 773	42 076	38 697
2	61 433	31 142	30 291	27 361	13 683	13 678	34 072	17 459	16 613
3	52 128	26 501	25 627	30 875	15 369	15 506	21 253	11 132	10 121
4	45 509	23 177	22 332	30 703	15 358	15 345	14 806	7 819	6 987
5	43 350	22 166	21 184	32 708	16 500	16 208	10 642	5 666	4 976

2-5 насны хөвгүүдийн 59.0 хувь, охидын 61.0 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод 2-5 насны нийт хүүхдийн 68.0 хувь нь хотод, 32.0 хувь нь хөдөөд тоологджээ. СӨБ-д хамрагдсан энэ насны бүлгийн хүүхдүүдийн 71.7 хувь нь хотод амьдарч байна /Хүснэгт 3.2/. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдүүдийн дунд 3-5 насны хүүхдүүдийн эзлэх хувь өндөр, 2 настай хүүхдүүдийнх бага байна. Хөдөөд цэцэрлэгт хамрагдаж байгаа хөвгүүд охидоосоо цөөн байна.

⁵ ҮСХ, “Статистикийн эмхтгэл 2010”, 2011 он

ХҮСНЭГТ 3.2. ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГ 2-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО,
НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Нас	Цэцэрлэгт хүмүүждэг			Хүйсийн бүтэц, %		Дүнд эзлэх хувь	
	Бүгд	Хүйс		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
		Эрэгтэй	Эмэгтэй				
БҮГД	121 647	60 910	60 737	50.1	49.9	100.0	100.0
2	27 361	13 683	13 678	50.0	50.0	22.5	22.5
3	30 875	15 369	15 506	49.8	50.2	25.2	25.5
4	30 703	15 358	15 345	50.0	50.0	25.2	25.3
5	32 708	16 500	16 208	50.4	49.6	27.1	26.7
ХОТ - БҮГД	88 577	44 602	43 975	50.4	49.6	100.0	100.0
2	20 590	10 311	10 279	50.1	49.9	23.1	23.4
3	23 225	11 643	11 582	50.1	49.9	26.1	26.3
4	22 188	11 197	10 991	50.5	49.5	25.1	25.0
5	22 574	11 451	11 123	50.7	49.3	25.7	25.3
ХӨДӨӨ - БҮГД	33 070	16 308	16 762	49.3	50.7	100.0	100.0
2	6 771	3 372	3 399	49.8	50.2	20.7	20.3
3	7 650	3 726	3 924	48.7	51.3	22.8	23.4
4	8 515	4 161	4 354	48.9	51.1	25.5	26.0
5	10 134	5 049	5 085	49.8	50.2	31.0	30.3

СӨБ-д хамрагддаггүй хүүхдүүдийн талаас илүү буюу 52.0 хувь нь хөвгүүд байгаа нь 2-5 насны нийт хөвгүүдийн 41.0 хувийг эзэлж байгаа юм. Цэцэрлэгт хүмүүждэггүй хөвгүүдийн 51.0 хувь, охидын мөн 51.0 хувь нь хотод тоологдсон байна.

ХҮСНЭГТ 3.3. ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГҮЙ 2-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО,
НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Нас	Цэцэрлэгт хүмүүждэггүй			Хүйсийн бүтэц, хувьс		Дүнд эзлэх хувь	
	Бүгд	Хүйс		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
		Эрэгтэй	Эмэгтэй				
БҮГД	80 773	42 076	38 697	52.1	47.9	100.0	100.0
2	34 072	17 459	16 613	51.2	48.8	41.5	42.9
3	21 253	11 132	10 121	52.4	47.6	26.5	26.2
4	14 806	7 819	6 987	52.8	47.2	18.6	18.1
5	10 642	5 666	4 976	53.2	46.8	13.5	12.9
ХОТ - БҮГД	41 354	21 525	19 829	52.1	47.9	100.0	100.0
2	19 321	9 947	9 374	51.5	48.5	46.2	47.3
3	10 738	5 620	5 118	52.3	47.7	26.1	25.8
4	6 681	3 473	3 208	52.0	48.0	16.1	16.2
5	4 614	2 485	2 129	53.9	46.1	11.5	10.7
ХӨДӨӨ - БҮГД	39 419	20 551	18 868	52.1	47.9	100.0	100.0
2	14 751	7 512	7 239	50.9	49.1	36.6	38.4
3	10 515	5 512	5 003	52.4	47.6	26.8	26.5
4	8 125	4 346	3 779	53.5	46.5	21.1	20.0
5	6 028	3 181	2 847	52.8	47.2	15.5	15.1

БҮХ ШАТНЫ СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 6-39 насны 1632.4 мянган хүн тоологдсоны 43.8 хувь нь аль нэг шатны сургуульд суралцдаг хүмүүс байна. Сургуульд суралцдаг хүмүүсийн 48.3 хувь нь эрэгтэйчүүд, 51.7 хувь нь эмэгтэйчүүд байв. Сургуульд суралцдаг 6-14 насны хүүхдүүдийн хувьд хүйсийн ялгаа байхгүй байна.

ХҮСНЭГТ 3.4. СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ 6-14 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Нас	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
6	20 003	19 459	102.8	12 790	12 339	103.7	7 213	7 120	101.3
7	21 231	20 439	103.9	13 284	12 775	104.0	7 947	7 664	103.7
8	21 592	20 877	103.4	13 209	12 855	102.8	8 383	8 022	104.5
9	22 351	21 942	101.9	13 726	13 434	102.2	8 625	8 508	101.4
10-14	114 838	113 992	100.7	70 167	70 194	100.0	44 671	43 798	102.0

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 7-29 насны хүн амын бараг тал хувь нь (47.8 хувь) сургуульд суралцаж байсан бол 2010 оны тооллогоор энэ насны хүмүүсийн 56.9 хувь нь сургуульд суралцаж байгаа гэж хариулсан нь 10 жилийн өмнөхөөс 9.1 пунктээр илүү байна. Харин 7-14 насны хүүхдүүдийн хувьд 97.2 хувь нь сургуульд суралцаж байгаа гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 3.5. 7-14 НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХУВИАР, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН


Нас	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010 ОН									
7	97.9	97.7	98.1	98.4	98.3	98.5	97.0	96.7	97.4
8	98.4	98.3	98.6	98.7	98.6	98.7	98.0	97.8	98.3
9	98.5	98.3	98.6	98.7	98.6	98.9	98.0	97.8	98.2
10	98.2	97.9	98.5	98.5	98.3	98.7	97.8	97.3	98.3
11	97.6	97.1	98.1	98.1	97.9	98.4	96.7	95.8	97.7
12	96.7	95.8	97.7	97.6	97.2	98.0	95.4	93.8	97.1
13	95.8	94.6	97.0	97.1	96.5	97.6	93.9	91.9	96.0
14	94.7	92.8	96.7	96.6	95.8	97.4	91.9	88.4	95.5
2000 ОН									
7	29.4	27.2	31.7	41.0	38.1	43.9	16.6	15.2	17.9
8	84.8	83.3	86.3	91.7	90.6	92.8	76.4	74.3	78.4
9	93.8	92.5	94.2	96.8	96.4	97.2	88.8	87.5	90.2
10	93.4	92.4	94.5	97.2	96.8	97.6	88.4	86.5	90.3
11	91.8	89.9	93.6	96.8	95.9	97.7	85.0	81.9	88.2
12	88.4	85.4	91.6	95.8	94.5	97.1	78.8	73.5	84.4
13	84.8	80.5	89.0	94.5	92.8	96.1	72.3	65.2	79.7
14	80.1	74.5	85.8	92.1	89.2	94.9	64.8	56.2	73.7

Долоон настай хүүхдүүдийн сургуульд хамрагдалт огцом нэмэгдсэн нь манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбоотой.

Боловсролын салбарт шинэчлэл хийж, 12 жилийн боловсрол эзэмшүүлэх болсонтой холбоотойгоор ЕБС-ийн 1-р ангид элсэх нас 6 наснаас эхэлж байгаа бөгөөд хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 6 настай 42.1 мянган хүүхэд тоологдсоны 93.6 хувь, үүний дотор энэ насны хөвгүүдийн 93.0 хувь, охидын 94.3 хувь нь сургуульд хамрагдаж байна. Зургаан настнуудын 62.0 хувь нь хотод тоологдсон бөгөөд эдгээр хүүхдүүдийн 96.1 хувь (хөвгүүдийн 95.8 хувь, охидын 96.5 хувь) нь сургуульд хамрагджээ. Харин хөдөөд тоологдсон энэ насны нийт хүүхдийн 89.6 хувь, үүнээс хөвгүүдийн 88.4 хувь, охидын 90.7 хувь нь сургуульд хамрагдсан нь хотынхтой харьцуулахад нэлээд доогуур байна.

Бага сургуульд суралцаж байгаа 6-11 насны 230.3 мянган хүүхэд тоологдсоны 50.9 хувь нь хөвгүүд, 49.1 хувь нь охид байна. Бага сургуульд суралцдаг эдгээр охид, хөвгүүд нь 6-11 насны нийт хүүхдийн 85.7 хувийг эзэлж байгаа юм.


ЗУРАГ 3.5. 6-11 НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Хотод тоологдсон 6-11 насны хөвгүүдийн бага сургуульд хамрагдалтын хувь охидынхоос 0.5 пунктээр, харин хөдөөд охидын хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс 0.4 пунктээр тус тус илүү байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор суурь боловсролд хамрагдаж байгаа 168.5 мянган хүүхэд тоологдсоны 50.0 хувь нь хөвгүүд, 50.0 хувь нь охид байна. Боловсролын шатлал ахихад сургуульд хамрагдаж байгаа хөвгүүдийн тоо цөөрч охид давамгайлах хандлага хот, хөдөөд ижил байна.

ЗУРАГ 3.6. 12-15 НАСНЫ ХҮҮХДИЙН СУУРЬ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



2010 оны тооллогоор Ерөнхий боловсролын сургууль болон Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-д суралцаж байгаа 112.8 мянган залуучуудын 49.0 хувь нь эрэгтэйчүүд, 51.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд энэ харьцаа хотод ижил, харин хөдөөд эрэгтэйчүүдийн хувь 47.0, эмэгтэйчүүдийнх 53.0 байна.


СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ

Хүн амын ялангуяа 6-15 насны охид, хөвгүүдийн сургууль хамрагдалтын түвшин хэр зэрэг байгааг илэрхийлдэг өөр нэг үзүүлэлт нь сургуулийн гадна байгаа буюу сургууль завсардсан⁶ хүүхдийн тоо юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр сургууль завсардсан 6-15 насны 16.6 мянган хүүхэд тоологдсоны 63.0 хувь нь хөвгүүд, 37.0 хувь нь охид байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн бараг тал хувийг 13-15 насны охид, хөвгүүд эзэлж байна. Мөн зургаан настнуудын хувьд сургууль завсардалт бусад насны бүлэгтэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд нийт завсардагчдын 16.0 хувийг эзэлж байгаа юм. Ер нь 10-аас дээш насны хүүхдүүд сургууль завсардах нь бусад насны охид, хөвгүүдээс илүү байна /Зураг 3.7/.


⁶ Сургуульд ороод завсардсан болон огт ороогүй завсардсан бүх хүүхдүүд

ЗУРАГ 3.7. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



Сургууль завсардсан 6-15 насны хүүхдүүдийн 28.9 хувь нь Хангайн бүсэд, 26.0 хувь нь Баруун бүсэд тоологдсон байна. Зүүн бүсэд сургууль завсардалт хамгийн бага буюу нийт завсардсан хүүхдүүдийн 7.2 хувь нь энэ бүсэд тоологджээ. Завсардагчдын дотор хөвгүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь аль ч бүсэд адил байна /Зураг 3.8/.

ЗУРАГ 3.8. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, ХҮЙС, БҮСЭЭР, 2010 ОН



ҮСХ-ны мэдээллээс үзэхэд 6-15 насны охид хөвгүүд ажил эрхлэх, сурах дургүй, өвчний улмаас, амьдралын гачигдал зэрэг шалтгаануудаар сургууль завсарддаг байна⁷.

⁷ ҮСХ: “Боловсрол, соёл, шинжлэх ухааны статистик-2010” танилцуулга

Сургууль завсардсан 6 настай хүүхдүүдийн дийлэнх нь Улаанбаатар хот болон Баян-Өлгий аймагт тоологдсон бөгөөд энэ нь бүх насанд хүйс харгалзахгүйгээр ижил байна. Баруун бүсийн аймгуудын хувьд Баян-Өлгий аймаг, Хангайн бүсэд Хөвсгөл аймаг, Төвийн бүсэд Төв, Зүүн бүсэд Сүхбаатар аймаг сургууль завсардалтаараа бусдаасаа өндөр байна.

Сургууль завсардагчдын дунд хүйсийн ялгаатай байдал их байна. Өөрөөр хэлбэл, сургууль завсардсан хөвгүүдийн хувийн жин бүх аймагт, аль ч насны хувьд охидынхоос өндөр байгаа юм.

ХҮСНЭГТ 3.6. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН


Аймаг, нийслэл	Сургууль завсардсан-бүгд			6-11 нас			12-15 нас		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	16 553	10 435	6 118	6 983	4 000	2 983	9 570	6 435	3 135
БАРУУН БҮС									
БҮГД	4 296	2 688	1 608	2 148	1 224	924	2 148	1 464	684
Баян-Өлгий	1 764	1 021	743	1 147	631	516	617	390	227
Говь-Алтай	361	241	120	124	71	53	237	170	67
Завхан	465	307	158	168	101	67	297	206	91
Увс	981	665	316	412	258	154	569	407	162
Ховд	725	454	271	297	163	134	428	291	137
ХАНГАЙН БҮС									
БҮГД	4 790	3 172	1 618	1 675	985	690	3 115	2 187	928
Архангай	915	613	302	309	187	122	606	426	180
Баянхонгор	777	503	274	265	156	109	512	347	165
Булган	324	221	103	132	78	54	192	143	49
Орхон	298	186	112	119	56	63	179	130	49
Өвөрхангай	1 172	793	379	421	262	159	751	531	220
Хөвсгөл	1 304	856	448	429	246	183	875	610	265
ТӨВИЙН БҮС									
БҮГД	2 294	1 474	820	920	539	381	1 374	935	439
Говьсүмбэр	53	35	18	24	15	9	29	20	9
Дархан-Уул	336	205	131	143	78	65	193	127	66
Дорноговь	294	186	108	116	69	47	178	117	61
Дундговь	239	149	90	83	47	36	156	102	54
Өмнөговь	303	194	109	104	62	42	199	132	67
Сэлэнгэ	523	329	194	228	133	95	295	196	99
Төв	546	376	170	222	135	87	324	241	83
ЗҮҮН БҮС									
БҮГД	1 191	795	396	391	233	158	800	562	238
Дорнод	344	223	121	122	70	52	222	153	69
Сүхбаатар	499	335	164	141	86	55	358	249	109
Хэнтий	348	237	111	128	77	51	220	160	60
УЛААНБААТАР									
Улаанбаатар	3 982	2 306	1 676	1 849	1 019	830	2 133	1 287	846

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 6-14 насны нийт хүүхдийн 4.2 хувь, сургуульд суралцаж байгаа гэж хариулсан хүүхдүүдийн 4.3 хувь нь суурь боловсролтой байгаа бөгөөд сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн 36.7 хувь нь бага боловсролтой байна. ЕБС-д суралцагчдын хүйсийн харьцаа бага, дунд ангийн түвшинд харьцангуй тэнцвэртэй байна.

6-14 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтад эцэг, эхийн халамж, анхаарал чухал бөгөөд хүний эрхийн болон хүүхдийн эрхийг хамгаалах тунхаглал, эрх зүйн актад хүүхэд эцэг, эхтэйгээ хамт амьдрах эрхтэй гэж заасан байдаг ч эцэг, эхийн хэн нэг нь эсвэл хоёулаа нас барах, түүнчлэн эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулж эсвэл тусгаарласан үед, мөн эцэг, эхийн хэн нэг нь эсвэл хоёулаа гадаад улсад урт хугацаагаар суралцах, ажиллахаар явсан үед хүүхэд зөвхөн эхтэйгээ эсвэл зөвхөн эцэгтэйгээ, зарим тохиолдолд өөр асран хамгаалагчтай байх тохиолдлууд байдаг.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод хамрагдсан 18 хүртэлх насны нийт хүүхдийн 83.4 хувь нь эцэг, эхтэйгээ, эсвэл хэн нэгэнтэй нь хамт, үлдсэн 16.6 хувь нь эцэг, эхээсээ өөр асран хамгаалагчтай амьдардаг байна. Эцэг, эхтэйгээ эсвэл хэн нэгэнтэй нь хамт амьдарч байгаа хүүхдүүдийн 85.7 хувь нь хоёуланттай нь, 11.9 хувь нь зөвхөн эхтэйгээ, 2.4 хувь нь зөвхөн эцэгтэйгээ хамт амьдардаг байна. Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг хөдөөгийн хүүхдүүд хотынхтой харьцуулахад илүү байгааг Зураг 3.9-өөс харж болно. Үүнээс гадна зөвхөн эхтэйгээ хамт амьдардаг хүүхдийн хувь хотод хөдөөгийнхөөс бараг 2 дахин их байна.


ЗУРАГ 3.9. 0-17 НАСНЫ ХҮҮХЭД, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ЭЦЭГ, ЭХТЭЙГЭЭ АМЬДАРДАГ ЭСЭХ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



Хүүхдийг бага байхад нь тэр дундаа сургуульд орох нас хүртэл өвөө, эмээ, ах, эгч, бусад хамаатныд нь байлгаж өсгөх тохиолдол манай улсад их байдаг бөгөөд энэ нь тооллогын дүнгээс харагдаж байгаа юм. Тухайлбал, 0-4 настай нийт хүүхдийн 18.2 хувь нь өвөө, эмээтэйгээ, 9.2 хувь нь ах, эгчтэйгээ, 9.0 хувь нь бусад төрөл садантайгаа амьдарч байгаа бол 10-14 насны өвөө, эмээ, төрөл садантайгаа хамт амьдардаг хүүхдүүдийн хувьд 0-4 насныхантай харьцуулахад хоёр дахин бага байна. Харин хамааралгүй хүмүүстэй хамт амьдарч байгаа хүүхдүүдийн хувийн жин нас ахих тусам нэмэгдэж байна. Үүнийг хамааралгүй хүмүүстэй амьдарч байгаа 0-4 настай хүүхдийн хувийн жин ердөө 0.6 байхад 5-9 настай хүүхдүүдийн хувьд 1.1, 10-14 настай хүүхдүүдийн хувьд 2.2, 15-17 насны хүүхдүүдийн хувьд 5.2 болж өссөнөөс харж болох юм.

Эцэг, эхээсээ өөр асран хамгаалагчийн хамт амьдардаг 18 хүртэлх насны хүүхдүүд хотод хөдөөгөөс илүү байна. 18 хүртэлх насны 10 хүүхэд тутмын 1 нь өвөө, эмээтэйгээ, 20 хүүхэд тутмын 1 нь ах, эгчтэйгээ, мөн 20 хүүхэд тутмын 1 нь бусад төрөлтэйгөө хамт амьдарч байгааг Зураг 3.10-аас харж болно.

ЗУРАГ 3.10. ЭЦЭГ, ЭХЭЭСЭЭ БУСАД АСРАН ХАМГААЛАГЧТАЙ АМЬДАРЧ БАЙГАА 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



Тооллогын үед ямар нэгэн асран хамгаалагчгүй 15 хүртэлх насны 281 хүүхэд тоологдсоны дийлэнх буюу 228 хүүхэд нь хотынх ажээ. Энэ тоо цөөн мэт харагдаж байгаа боловч томчуудын хараа хяналтгүй хүүхэд байсаар байгааг илтгэж байна.


2010 оны тооллогоор улсын хэмжээнд тоологдсон 713.8 мянган өрхийн 446.7 мянга буюу 62.6 хувь нь 16 хүртэлх насны хүүхэдтэй өрх байна. Хүүхэдтэй өрхийн хувь 2000 онтой харьцуулахад 13.8 пунктээр буурсан байгаа нь 1994-2005 оны хооронд төрөлт багассантай холбоотой юм. Харин 2006 оноос төрөлт нэмэгдэж, төрөлтийн түвшин 1980-аад оныхтой ойролцоо болсон нь 2005-2009 онуудад Засгийн газраас “Хүүхдийн мөнгө” хөтөлбөр хэрэгжүүлсэнтэй болон хүн амын дунд тархсан “алтан гахай жилд хүүхэд төрүүлэх сайн”, “хулгана жилд төрсөн хүүхэд амны хишигтэй байдаг” гэсэн итгэл үнэмшилтэй холбоотой байж болох юм. 16 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн тоо хот, хөдөөд ч мөн өмнөх тооллогоос багассан байна.

ХҮСНЭГТ 3.7. 16 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

	2000 он			2010 он		
	Нийт өрхийн тоо	16 хүртэлх насны хүүхэдтэй өрх		Нийт өрхийн тоо	16 хүртэлх насны хүүхэдтэй өрх	
		Тоо	Хувь		Тоо	Хувь
БҮГД	541 149	419 640	76.4	713 780	446 690	62.6
Хот	296 398	230 430	77.7	479 503	295 665	61.7
Хөдөө	244 751	184 156	75.2	234 277	151 025	64.5

Хүүхэдтэй 446.7 мянган өрхийн 295.7 мянга нь хотын, 151.0 мянга нь хөдөөгийн өрх байна. Улсын хэмжээнд хүүхэдтэй 5 өрх тутмын 4 нь нэг эсвэл хоёр хүүхэдтэй өрх байгаа бөгөөд нийт хүүхэдтэй өрхийн хувьд хүүхдийн дундаж тоог тооцож үзвэл 1.8 байгаа юм. Хүүхэдтэй өрх нь хот, хөдөөд ялгаатай байгаа бөгөөд хөдөөд олон хүүхэдтэй байх хандлагатай байна. Тухайлбал, хотод нэг хүүхэдтэй өрх хөдөөгийнхөөс 10.7 пунктээр их байхад, хөдөөд гурваас олон хүүхэдтэй өрх хоттой харьцуулахад 1.0-6.2 пунктээр их байгаа нь харагдаж байлаа /Зураг 3.11/.

ЗУРАГ 3.11. 16 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ, ХҮҮХДИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН




3.2. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Онолын хувьд хүүхэд, өндөр настнууд эцэг эх, асран хамгаалагчийнхаа хамт шилждэг бөгөөд хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 0-14 насны нийт хүүхдийн 86.8 хувь нь төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд ороогүй, 13.2 хувь нь тухайн тоологдсон газраа шилжиж ирсэн хүүхдүүд байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг тоолсон бөгөөд 0-14 насны 11.3 мянган хүүхэд тоологдсоны 50.2 хувь нь хөвгүүд 49.8 хувь охид байна. Эдгээр хүүхдүүдийн 40.7 хувь нь 0-4, 28.1 хувь нь 5-9, 31.3 хувь нь 10-14 насны хүүхдүүд байв. Гадаадад урт хугацаагаар амьдарч буй эдгээр хүүхдүүдийн 20.5 хувь нь АНУ-д, 13.0 хувь нь БНСУ-д, 9.1 хувь нь Чех улсад, 7.4 хувь нь БНХАУ-д, 6.6 хувь нь Япон улсад гэх мэтээр дэлхийн өнцөг булан бүрт оршин сууж байна.

Гадаад улсад төрөөд тооллогын үед эх орондоо оршин сууж байсан 0-14 насны 4.9 мянган хүүхэд тоологдсоны 49.5 хувь нь 0-4 насны хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдийн 41.0 хувь нь үндсэн газартаа ирээд 1-3 жил амьдарч байгаа хүүхдүүд юм.

ЗУРАГ 3.12. ГАДААДАД ТӨРСӨН МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ 0-14 НАСНЫ ХҮҮХЭД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ҮНДСЭН НЭГГЖДЭЭ АМЬДАРЧ БУЙ ХУГАЦААГААР, 2010 ОН



Сүүлийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн 18.9 мянга нь буюу 16.6 хувь нь 0-14 насны хүүхдүүд байна. Эдгээр хүүхдүүдийн 50.9 хувь нь хөвгүүд, 49.1 хувь нь охид байна. Энэ нь гэр бүлээрээ шилжих шилжилт дотоод шилжих хөдөлгөөний тодорхой хувийг эзэлж байгааг харуулж байгаа юм.


3.3. ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ

Мэдээллийн эрин зуун гэгдэж буй өнөө үед мэдээлэл холбооны технологийг ашиглан бусадтай харилцаж, мэдээлэл авах явдал түгээмэл болсон бөгөөд хүүхэд бүр төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл олж авах эрхтэй байдаг. Энэ удаагийн тооллогоор 6 ба түүнээс дээш насны бүх хүнээс гар утастай эсэх болон интернет хэрэглэдэг эсэхийг асуусан нь онцлог төдийгүй Монгол Улсын Засгийн газраас 2008 онд баталсан МХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тооцох боломж олгож байгаагаараа давуу гэдгийг дурдвал зохино.

ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Тооллогод хамрагдсан 6 ба түүнээс дээш насны нийт хүн амын 74.0 хувь, 6-14 насны нийт хүүхдийн 39.3 хувь нь гар утас хэрэглэдэг байна. Хүүхдийн нас ахих тусам гар утасны хэрэглээ нь жигд нэмэгдэж байгааг Зураг 3.13-аас харж болно. Гар утас хэрэглэдэг хүүхдүүдийн хувьд хүйсээр төдийлөн ялгаагүй байгаа бөгөөд охидын хувь хөвгүүдийнхээс зарим насанд 0.1 пунктээр л илүү байв. Гар утас хэрэглэдэг нийт хүүхдийн 76.6 хувь нь хот, суурин газар, үлдсэн хувь нь хөдөө амьдарч байгаа нь хот, суурин газар үүрэн телефон хэрэглэх боломж илүү байдгаас хамаарч байна.

ЗУРАГ 3.13. ГАР УТАС ХЭРЭГЛЭДЭГ 6-14 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН




ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ

6-14 насны нийт хүүхдийн 18.0 хувь нь ямар нэг байдлаар интернет хэрэглэдэг байна. Хүүхдийн нас ахих тусам интернетийн хэрэглээ нь нэмэгдэж байгаа нь нэг талаас хичээл, даалгавар хийхэд ашиглах шаардлага илүү гардаг, нөгөө талаас интернет хэрэглэх нь тодорхой хэмжээний компьютерийн төдийгүй хэлний мэдлэг шаарддагтай холбоотой байж болох юм. Интернет хэрэглэдэг хөвгүүд охидоосоо илүү байна.

Интернет хэрэглэдэг нийт хүүхдүүдийн 92.5 хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа нь интернет хэрэглэх боломж, хүртээмж илүү байдагтай холбоотой юм. Хүүхдүүд орчин үеийн мэдээллийн технологийг сайн ашиглаж, хэрэглэж байгаа нь нэг талаас сайшаалтай ч нөгөө талаас буруу зүйлд уруу татагдах, хүний наймаанд өртөх зэрэг шинэ төрлийн эрсдлийг дагуулж байдаг тул хүүхдүүд ямар зорилгоор, ямар мэдээллийг интернетээс авдаг талаар нарийвчлан судлах хэрэгтэй.

ЗУРАГ 3.14. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ 6-14 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



3.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД

Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” болон “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал” зэрэг өөрийн улс орны болон олон улсын хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хүүхдийн тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай болдог.

“Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй” гэж тооцдог.⁸

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР


Монгол Улсын хэмжээнд тооллогод хамрагдсан 15 хүртэлх насны нийт хүүхдийн 1.3 хувь нь буюу 9.5 мянган хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй гэж хариулсан байна. Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд тутмын 2 нь төрөлхийн, 1 нь хөгжлийн олдмол бэрхшээлтэй гэж үзжээ. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 53.7 хувь, хөгжлийн олдмол бэрхшээлтэй нийт хүүхдийн 56.7 хувь нь хөвгүүд байна.

ХҮСНЭГТ 3.8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй		Хөгжлийн олдмол бэрхшээлтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
БҮГД	9 461	100	6 273	66.3	3 188	33.7
0-4	1 957	20.7	1 436	73.4	521	26.6
5-9	3 068	32.4	2 106	68.8	962	31.2
10-14	4 436	46.9	2 731	61.6	1 705	38.4

Насны хувьд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 77.1 хувийг 5-14 насны, хөгжлийн олдмол бэрхшээлтэй хүүхдүүдийн 53.5 хувийг 10-14 насны хүүхдүүд эзэлж байв.


ЗУРАГ 3.15. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН



⁸ Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл II боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 280

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд хөдөлгөөний (28.6 хувь) болон харааны (19.8 хувь) бэрхшээл хамгийн их байна. Хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхэд тутмын 1 нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

ЗУРАГ 3.16. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН




Хүүхдийн нас нэмэгдэх тусам харааны, сонсголын болон сэтгэцийн бэрхшээл нэмэгдэж байна. Харин хөдөлгөөний бэрхшээлийн хувьд нас нэмэгдэх тусам буурч 10-14 настай хүүхдүүдийг 0-4 настай хүүхдүүдтэй харьцуулахад гуравны нэгээр буурсан байна /Хүснэгт 3.9/.

ХҮСНЭГТ 3.9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Бэрхшээлийн хэлбэрээр					
		Харааны	Ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Бусад
БҮГД	9 461	19.8	12.9	8.1	28.6	16.9	13.6
0-4	1 957	18.7	9.5	4.0	37.9	11.8	18.1
5-9	3 068	19.6	15.6	6.6	29.2	15.7	13.3
10-14	4 436	20.4	12.6	11.0	24.0	20.0	11.9

Охидтой харьцуулахад хөвгүүдийн хувьд ярианы болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээл их, харин охидын хувьд харааны болон хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл их байна.

ЗУРАГ 3.17. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН




Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийн хувьд хөдөлгөөний болон сэтгэцийн бэрхшээл голлох хэлбэр болж байгаа бол хөгжлийн олдмол бэрхшээлтэй охид, хөвгүүдийн хөдөлгөөний болон харааны бэрхшээл зонхилох хэлбэр болж байна. Ердийн өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн болон ахуйн осол зэрэг шалтгаануудын улмаас олдмол төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болдог бол төрөлхийн хөгжлийн бэрхшээл нь удамшил, эцэг, эхийн амьдралын хэвшил, зуршил (архи, тамхи хэрэглэх гэх мэт), эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны байдлаас хамаардаг байж болох юм.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй 6-14 насны хүүхдүүдийн 70.7 хувь нь боловсрол эзэмшээгүй хүүхдүүд байгаа ч эдгээр хүүхдүүдийн 56.9 хувь нь бичиг үсэг мэддэг байна.

Бичиг үсэг мэддэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 6 наснаас эхлэн өсөөд, 11 наснаас буурсан дүр зураг харагдаж байна. Энэ төлөв байдал хүйсийн хувьд ялгаагүй байна /Зураг 3.18/.


ЗУРАГ 3.18. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ, БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙСЭЭР, 2010 ОН



СӨБ-Д ХАМРАГДАЛТ

2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй 2.0 мянган хүүхэд тоологдсоны 38.7 хувь нь цэцэрлэгт хүмүүждэг, харин үлдсэн 61.3 хувь цэцэрлэгт хүмүүждэггүй байна. Цэцэрлэгт хүмүүждэг хүүхдүүдийн 74.4 хувь нь хотод, 25.6 хувь нь хөдөө тоологдсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй цэцэрлэгт хүмүүждэг хүүхдүүдийн дотор хөвгүүд илүү байгаа юм.


ЗУРАГ 3.19. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СӨБ-Д ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ


Хөгжлийн бэрхшээлтэй 6-14 насны хүүхдүүдийн 67.0 хувь нь сургуульд суралцаж байгаагийн 53.0 хувь нь хөвгүүд, 47.0 хувь нь охид байна. Эдгээр хүүхдүүдийн 36.5 хувь нь 6-9 насны, 63.5 хувь нь 10-14 насныхан байв.

ЗУРАГ 3.20. СУРГУУЛЬД ХАМРАГДСАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Сургуульд сурдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 58.6 хувь нь хотод, 41.4 хувь нь хөдөөд тоологджээ. Хотод амьдардаг хүүхдүүдийн хувьд жирийн болон тусгай сургуулиудад суралцах боломж нь хөдөөд байгаа хүүхдүүдээс арай илүү юм.

ЗУРАГ 3.21. СУРГУУЛЬД СУРДАГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН




БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Хөгжлийн бэрхшээлтэй 6-14 насны нийт хүүхдийн 29.2 хувь нь бага болон суурь боловсрол эзэмшсэн байна. Эдгээр хүүхдүүдийн 93.4 хувь нь бага боловсролтой, 6.6 хувь нь суурь боловсрол эзэмшсэн байлаа. Бага боловсролтой хүүхдүүдийн 60.0 хувь нь 13-14 насны хүүхдүүд байна /Зураг 3.22/.

Суурь боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дийлэнх нь 14 настнууд, харин хүйсийн хувьд хөвгүүд охидоосоо илүү байна.

ЗУРАГ 3.22. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БАГА БОЛОВСРОЛТОЙ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙСЭЭР, 2010 ОН



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАЛУУЧУУД



НҮБ-аас гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын удирдамж, зарчмууд”-ын 3.97-д заасанчлан “залуучууд” гэдэгт 15-24 насны хүн амыг хамааруулаа. Энэ бүлэгт залуучуудын гэрлэлтийн байдал, шилжих хөдөлгөөн, боловсрол, гар утас, интернетийн хэрэглээг авч үзсэнээс гадна залуучуудын эрүүл мэндийн байдлыг төрөлхийн болон олдмол хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр гаргаж харуулахыг зорив.


НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хэргийн газрын Хүн амын хэлтсээс гаргасан тооцоогоор дэлхийн 7 тэрбум хүн амын бараг тал хувь нь 24 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байгаа бөгөөд түүний 1.2 тэрбум нь 10-19 насныхан байгаа юм. Дунд орлоготой, хурдацтай хөгжиж байгаа бага орлоготой зарим орнуудад ажил эрхэлж буй залуучууд их байгаа нь зурвасхан хугацаанд тухайн улс орнуудын хөгжлийн түлхэх хүч болж байгааг статистик харуулж байна⁹.

4.1. ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хүн ам зүйн шинжлэх ухаанд хүн амын гэрлэлтийн байдал гэдэгт гэрлэлт, цуцлалт, бэлэвсрэлт, тусгаарлалт, дахин гэрлэлт зэрэг ухагдахууныг цогцоор илэрхийлдэг.

Хүн амын гэрлэлтийн байдлыг судлах хамгийн гол үзүүлэлтийн нэг нь анхны гэрлэлтийн дундаж нас бөгөөд энэ үзүүлэлтийг тодорхойлсноор тухайн улсын хүн амын гэрлэлтийн ерөнхий төлөв байдлыг дүгнэх боломжтой болдог. Манай хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас өөрчлөгдөж, 2000 оны тооллогынхоос эрэгтэйчүүдийнх 0.5 жилээр, эмэгтэйчүүдийнх мөн 0.5 жилээр нэмэгдсэн байна /Зураг 4.1/.

ЗУРАГ 4.1. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, ХҮЙСЭЭР, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Гэрлэх үйл явц нь үндэсний уламжлалтай холбоотой байдгаас түүхийн богино хугацаанд эрс өөрчлөлт ордоггүй боловч улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн үеийн онцлогтой холбоотойгоор өөрчлөлт гарсаар байдаг.

⁹ UNFPA: State of world population 2011

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнг 1979 оныхтой харьцуулахад 18-19 насны эрэгтэйчүүдийн гэрлэлт 1.4 пунктээр нэмэгдсэн байхад энэ насны эмэгтэйчүүдийн гэрлэлт 2.7 пунктээр буурч, 20-24 насны хувьд эрэгтэйчүүдийн гэрлэлт өсөөд харин эмэгтэйчүүдийнх 11.2 пунктээр багассан бол хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 18-24 насны залуучуудын дунд огт гэрлээгүй залуучууд 73.0 хувь эзэлж байгааг хүйсээр авч үзвэл энэ насны эрэгтэйчүүдийн 78.8 хувь, эмэгтэйчүүдийн 67.1 хувь нь огт гэрлээгүй байна.

Тооллого хоорондын жилүүдэд гэрлэх үйл явцын үндсэн төрх хэвээр хадгалагдаж, харин нарийвчлан шинжлэхэд зарим нэг сонирхолтой өөрчлөлтүүд гарсан нь ажиглагдлаа. Хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол 18-24 насны залуучуудын дунд огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 2010 оны тооллогоор 1979 оныхоос эрэгтэйчүүдийн хувьд 3.2 пунктээр буурч, эмэгтэйчүүдийн хувьд 12.1 пунктээр өссөн, 1989 оныхоос эрэгтэйчүүдэд 3.6 пунктээр буурсан, эмэгтэйчүүдэд 6.4 пунктээр өндөр, харин 2000 оныхоос огт гэрлээгүй эрэгтэйчүүдийн эзлэх хувь 6.7, эмэгтэйчүүдийнх 7.0 пунктээр буурсан байна. /Хүснэгт 4.1/.


ХҮСНЭГТ 4.1. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР

Насны бүлэг	Гэрлэлтийн байдал				Бүгд	
	Огт гэрлээгүй	Гэрлэсэн	Цуцалсан	Бэлэвсэн	Хувь	Тоо
1979 ОН						
18-19	98.3	1.7	-	-	100.0	35 153
20-24	73.1	26.4	0.4	0.1	100.0	64 083
Эрэгтэй - Бүгд	82.0	17.7	0.3	-	100.0	99 236
18-19	84.5	15.1	0.3	0.1	100.0	33 646
20-24	39.9	58.0	1.8	0.3	100.0	65 533
Эмэгтэй - Бүгд	55.0	43.5	1.3	0.2	100.0	99 179
1989 ОН						
18-19	98.6	1.4	-	-	100.0	43 761
20-24	75.1	24.6	0.2	0.1	100.0	97 505
Эрэгтэй - Бүгд	82.4	17.4	0.2	-	100.0	141 266
18-19	91.6	8.2	0.2	0.1	100.0	41 136
20-24	47.8	50.8	1.1	0.3	100.0	98 547
Эмэгтэй - Бүгд	60.7	38.3	0.8	0.2	100.0	139 683
2000 ОН						
18-19	96.8	3.1	0.1	-	100.0	133 327
20-24	70.7	28.8	0.5	-	100.0	118 023
Эрэгтэй - Бүгд	85.5	14.2	0.2	-	100.0	251 350
18-19	87.4	12.4	0.2	-	100.0	130 031
20-24	51.7	46.8	1.3	0.2	100.0	117 728
Эмэгтэй - Бүгд	74.1	25.1	0.6	0.1	100.0	247 759
2010 ОН						
18-19	97.3	2.6	0.1	-	100.0	56 324
20-24	71.7	27.8	0.5	-	100.0	147 472
Эрэгтэй - Бүгд	78.8	20.9	0.3	-	100.0	203 796
18-19	92.2	7.7	0.1	-	100.0	54 875
20-24	57.7	41.3	0.9	0.1	100.0	144 711
Эмэгтэй - Бүгд	67.1	32.1	0.7	0.1	100.0	199 586

Гэрлэлтийн байдал нь амьдралын хугацаа, насжилтын үйл явцтай нягт холбоотой байдаг тул түүнийг нас, хүйсийн ялгавартай байдлаар авч судлах хэрэгтэй байдаг. Огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 15-19 насны бүлэгт хамгийн өндөр, түүний дотор энэ насны эрэгтэйчүүдийн дийлэнхи нь гэрлээгүй байгаа нь манай улсын “Гэр бүлийн тухай” хуулинд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй гэрлэх насыг 18 насаар заасан байдагтай холбоотой байж болох юм. 15-19 насны огт гэрлээгүй залуучуудын 45.0 хувь нь 15-18 насныхан, тэдний 51.0 хувь эрэгтэйчүүд байна.

15-19 насны огт гэрлээгүй хүн амыг хүйсээр авч үзэхэд бусад насны бүлгүүдээс харьцангуй бага зөрөөтэй, тухайлбал 1979 онд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 13.6, 1989 онд 7.4, 2000 онд 4.3 пунктээр, 2010 онд 2.4 пунктээр (тооллогын он хойшлох тусам багассан байна) их байна. Харин 20-24 насны бүлэгт энэ зөрөө улам нэмэгдэж байна.


ЗУРАГ 4.2. ОГТ ГЭРЛЭЭГҮЙ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Гэр бүл нь нийгмийн байнгын анхааралд байх ёстой үнэт зүйл, нийгмийн тогтвортой байдлыг хангагч хамтын хүч, нийгэм оршин тогтнох нийтлэг хэлбэр юм. Гэрлэлт, гэрлэлтийн харилцаа нь хоёр хүний хувийн хэрэг мэт боловч өөрийн утга агуулгатай, ач холбогдол бүхий нийгмийн чухал үзэгдэл юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээс харахад 15-24 насны залуучуудын 14.3 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 5.2 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй буюу хамт амьдардаг хосууд байна.

ЗУРАГ 4.3. ГЭР БҮЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



Сүүлийн жилүүдэд хамтран амьдрах явдал залуучуудын дунд нэлээд байгаа бөгөөд хот, хөдөөгүй ажиглагдах болжээ. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогод 15-24 насны 32660 залуучууд, үүнээс 38.8 хувь нь эрэгтэйчүүд, 61.2 хувь нь эмэгтэйчүүд, хотод 8481 эрэгтэйчүүд, 13155 эмэгтэйчүүд, хөдөөд 4191 эрэгтэйчүүд, 6833 эмэгтэйчүүд батлуулаагүй гэр бүлтэй буюу хамтран амьдардаг гэж тоолуулсан бол 2010 оны тооллогын дүнгээр 33345 болж, үүнээс 50.1 хувь нь эрэгтэй, 49.9 хувь нь эмэгтэйчүүд болж нэмэгдсэн байна. Хөдөөгийн залуучуудаас хотын залуучууд, түүний дотор эмэгтэйчүүд хостойгоо гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрах нь илүүтэй байна. Жишээлбэл, хотод тоологдсон 15-24 насны хамтран амьдрагчдын тоо хөдөө тоологдсоноос 5.9 дахин нэмэгдсэн байна.

Гэр бүл салалт нь эрх зүйн үүднээс батлагдан тогтоогдсон гэр бүлийн харилцаа хууль эрх зүйн үндэслэлтэйгээр төгсгөл болох үзэгдэл юм. Сүүлийн 2 тооллогын дүнгээс харахад гэр бүлээ цуцалсан, тусгаарласан 15-24 насны залуучуудын тоо 2010 оны тооллогоор 2026 болж, 2000 оны тооллогынхоос 7.7 хувиар буурчээ. Мөн энэ насны бэлэвсэн залуучуудын тоо 2000 оныхоос 35.0 хувиар буурсны дотор 15-24 насны бэлэвсэн эрэгтэйчүүд 2.2 дахин, эмэгтэйчүүдийнх 1.5 дахин буурчээ /Хүснэгт 4.2/.


ХҮСНЭГТ 4.2. 15-24 НАСНЫ ЦУЦАЛСАН, БЭЛЭВСЭН ЗАЛУУЧУУД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ХҮЙСЭЭР, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР

Хүйс	15-19		20-24	
	Цуцалсан	Бэлэвсэн	Цуцалсан	Бэлэвсэн
1979 ОН				
Эрэгтэй	0.0	0.0	0.4	0.1
Эмэгтэй	0.3	0.1	1.8	0.3
1989 ОН				
Эрэгтэй	0.0	0.0	0.2	0.1
Эмэгтэй	0.2	0.1	1.1	0.3
2000 ОН				
Эрэгтэй	0.0	0.0	0.5	0.0
Эмэгтэй	0.1	0.0	1.3	0.0
2010 ОН				
Эрэгтэй	0.0	0.0	0.4	0.0
Эмэгтэй	0.0	0.0	0.9	0.1

Өрхийн тэргүүн нас эцэслэсний дараа хүүхдээрээ өрх тэргүүлүүлэх уламжлал бидэнд байдаг бөгөөд гэр бүл цуцлалт, бэлэвсрэлт нь эмэгтэйчүүд өрх тэргүүлэх шалтгаан болж байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрх тэргүүлэн амьдарч байгаа 15-24 насны 8.6 мянган эмэгтэйчүүд байгаагийн 94.3 хувь нь огт гэр бүл болоогүй эмэгтэйчүүд байна.

Өрх тэргүүлэн амьдарч байгаа залуу эмэгтэйчүүдийн 5.7 хувь нь гэр бүл салалт, бэлэвсрэлтээс үүдэн өрх тэргүүлж байна. Гэр бүл салалтаас үүдэн өрх толгойлж байгаа 15-24 насны эмэгтэйчүүдийн 67.4 хувийг гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүс эзэлж байна.

ЗУРАГ 4.4. ӨРХ ТЭРГҮҮЛЭН АМЬДАРЧ БАЙГАА ЗАЛУУЧУУД,
НАС, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, 2010 ОН



Өрх тэргүүлэн амьдарч байгаа 15-24 насны залуучуудын 88.5 хувь нь хотод, 11.5 хувь нь хөдөөд тоологдсон бөгөөд хотын эмэгтэйчүүдийн 88.3 хувь, хөдөөгийн эмэгтэйчүүдийн 63.8 хувь нь мөн л гэр бүл цуцлалтаас үүдэн өрх тэргүүлэн амьдрах болсон байна.

4.2 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН


Хүн амын шилжих хөдөлгөөн нь хүн амын тоо, бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчилдөг гол хүчин зүйл юм. Шилжих хөдөлгөөнийг хэв шинжийн талаас нь 1) гадаад шилжих хөдөлгөөн, 2) дотоод шилжих хөдөлгөөн гэж ангилдаг. Гадаад шилжих хөдөлгөөн нь улс орны хэмжээний хүн амын тоо, бүтцийг өөрчилдөг бол дотоод шилжих хөдөлгөөн нь аймаг, сумдын хүн амын тоо, бүтцийг өөрчилдөг.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хэргийн газрын Хүн амын хэлтсээс гаргасан тооцоогоор, өнөөдөр дэлхийн хүн ам 7 тэрбум болж байгаа бөгөөд түүний 214 сая нь төрсөн улсаасаа өөр улсад амьдарч байна. 2010 онд АНУ (42.8 сая), ОХУ (12.3 сая), Герман (10.8 сая), Саудын Араб (7.3 сая), Канад (7.2 сая) улсууд хамгийн олон шилжин ирэгчдийг бусад улс орнуудаас хүлээн авсан бол хамгийн олон шилжигчдийг бусад улс орон руу илгээсэн топ 3 орон нь БНХАУ (35.0 сая), БНЭУ (20.0 сая), Филиппин (7.0 сая) улсууд байна⁹.

Манай улсын хувьд хүн амын гадаад шилжих хөдөлгөөний талаарх тогтмол давтамжтайгаар гардаг албан ёсны статистикийн мэдээлэл байхгүй бөгөөд хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг тоолсон юм. Энэ тооллогын дүнгээр манай улсын иргэн 15-24 насны 29.6 мянган залуучууд дэлхийн өнцөг булан бүрт амьдарч байна. Эдгээр залуучуудын 49.3 хувь нь эрэгтэйчүүд, 50.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Нас ахих тутам аль ч хүйсийн хувьд тоо нь нэмэгдсээр 21-ээс дээш насанд илүү их өсөлттэй байна.

⁹ UNFPA: State of world population 2011

ЗУРАГ 4.5. ГАДААДАД 6 САРААС ДЭЭШ ХУГАЦААГААР ОРШИН СУУЖ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



Гадаадад урт хугацаагаар байнга амьдарч байгаа 15-24 насны залуучуудын 31.0 хувь нь 15-19 насныхан байна. 15-24 насны эдгээр залуучуудын талаас илүү буюу 57.3 хувь нь БНСУ (19.9%), БНХАУ (14.1%), АНУ (13.2%), ОХУ (10.1)-д оршин сууж байна.

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн нь хөдөөгөөс хот руу, хөдөөгөөс хөдөө рүү, хотоос хот руу, хотоос хөдөө рүү чиглэсэн гэсэн 4 урсгалтай бөгөөд ядуу буурай орнуудад хөдөөгөөс хөдөө рүү чиглэсэн шилжилт голлож байдаг бол хөгжиж буй орнуудад хөдөөгөөс хот руу шилжих шилжилт зонхилдог байна. Манай улсын хувьд ч шилжих хөдөлгөөний энэ урсгал давамгайлах шинжтэй байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 15-24 насны 549.8 мянган залуучууд тоологдсоны 55.1 хувь нь төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд оролцоогүй залуучууд байна. Эдгээр залуучуудын 4.6 хувь нь буюу 25.5 мянга нь тоологдсон газартаа шилжиж ирээд 5-6 жил оршин сууж байна. Сүүлийн 5-6 жилийн дотор шилжих хөдөлгөөнд оролцсон 15-24 насны залуучуудын 30.4 хувь нь 15-19 насныхан, 69.6 хувь нь 20-24 насныхан байна. Хүйсээр нь авч үзвэл 53.0 хувь нь эрэгтэйчүүд, 47.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Шилжих хөдөлгөөнд оролцож байнга оршин суудаг газраа шилжин ирээд 5-6 жил болж буй эдгээр залуучуудын 88.2 хувь нь хотод тоологджээ.

Байнга оршин суудаг газраа шилжин ирээд 5-6 жил болж буй залуучуудын 30.4 хувь нь 15-19 насныхан, 69.6 хувь нь 20-24 насныхан байна. Сүүлийн 5-6 жилийн дотор шилжих хөдөлгөөнд оролцож тооллогын үед байнга оршин суудаг газартаа тоологдсон 15-24 насны залуучуудын 53.0 хувь нь эрэгтэйчүүд 47.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 4.3. ТООЛОГДСОН ГАЗАРТАА ШИЛЖИЖ ИРЭЭД 5-6 ЖИЛ ОРШИН СУУЖ БҮЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Хүйс	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	15-19	20-24	Бүгд	15-19	20-24	Бүгд	15-19	20-24
БҮГД	98 288	7 775	17 768	81 642	6 929	15 609	16 646	846	2 159
Эрэгтэй	51 029	4 226	9 320	40 541	3 630	7 651	10 488	596	1 669
Эмэгтэй	47 259	3 549	8 448	41 101	3 299	7 958	6 158	250	490

Сүүлийн 5-6 жилд Улаанбаатар хотод 15-24 насны 166.4 мянган залуучууд шилжиж суурьшсан бөгөөд эдгээрийн 41.5 хувь нь 15-19 насныхан, 58.5 хувь нь 20-24 насныхан байна. Хүйсээр нь авч үзвэл, 47.1 хувь нь эрэгтэйчүүд, 52.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Улаанбаатар хот руу Төв (15.5 мянга), Өвөрхангай (11.6 мянга), Архангай (10.8 мянга), Завхан (10.7 мянга), Увс (10.2 мянга) аймгуудаас хамгийн олон залуучууд шилжиж ирсэн байна.

Сүүлийн 5-6 жилд Дархан-Уул (11.7 мянга), Орхон (10.6 мянга), Сэлэнгэ (6.2 мянга), Төв (5.2 мянга) аймгууд хамгийн олон залуучуудыг хүлээн авч Улаанбаатар хотын дараа орж байгаа юм. Энэ хугацаанд Дорноговь аймаг 4.6 мянга, Өмнөговь аймаг 4.5 мянган залуучуудыг хүлээн авсан байна.


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр, сүүлийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцсон 114.0 мянган хүний 42.6 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байгаа нь их, дээд, мэргэжлийн сургуульд суралцагчдыг тухайн суралцаж буй газарт нь тоолсонтой холбоотой байж болох юм. Шилжих хөдөлгөөнд оролцсон эдгээр залуучуудын 49.1 хувь нь эрэгтэйчүүд, 50.9 хувь нь эмэгтэйчүүд байна /Хүснэгт 4.4/.

ХҮСНЭГТ 4.4. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь
БҮГД	48 620	100.0	23 884	100.0	24 736	100.0
15-19	22 898	47.1	10 645	44.6	12 253	49.5
20-24	25 722	52.9	13 239	55.4	12 483	50.5

Гадаадад төрөөд хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үед эх орондоо амьдарч байгаа 15-24 насны 2.7 мянган залуучууд байгаагийн 36.1 хувь нь 15-19 насныхан, 63.9 хувь нь 20-24 насны залуучууд байна. Эдгээр залуучуудын 40.8 хувь нь Монголдоо ирээд 1 жил хүрэхгүй хугацаанд амьдарч байна.

ЗУРАГ 4.6. ГАДААДАД ТӨРСӨН МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ҮНДСЭН НЭГЖДЭЭ АМЬДАРЧ БУЙ ХУГАЦААГААР, 2010 ОН



4.3 БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

2010 оны тооллогоор 6 ба түүнээс дээш насны хүн бүрээс боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, 2-39 насны хүн амаас аль нэг шатны сургуульд суралцаж байгаа эсэхийг асуусан.


4.3.1 ЗАЛУУЧУУДЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Бичиг үсгийн мэдлэг нь хүний эрхийн хамгийн чухал хэсэг бөгөөд чанартай суурь боловсрол нь бичиг үсгийн мэдлэгтэй хүүхдийг цаашдын амьдрал, сургалт боловсролд хөтөлдөг. Нэгдмэл, боловсролтой ард түмэн хөгжлийн тулгамдсан асуудлууд, сорилтыг давах, шийдвэрлэх хүчирхэг хүч болдог¹⁰.

Бичиг үсгийн мэдлэг гэсэн энэ үзүүлэлтийг тооцож буй зорилго нь хүн амын тэр дундаа насанд хүрэгчдийн оюуны потенциалын өсөлт, түүний нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд оруулж буй хувь нэмрийг харуулах явдал юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор манай улсын 15-24 насны залуучуудын бичиг үсгийн мэдлэг 98.0 хувьтай байна. НҮБСХ-ийн мэдээллээр, 2009 оны байдлаар энэ үзүүлэлт бусад орнуудад тухайлбал ОХУ (100.0%), Хятад (99.0%), Малайз (99.0%) улсуудад манай улсынхаас өндөр, Бангладеш (75.0%), Непал (82.0%) зэрэг улсуудад доогуур байгаа ч эдгээр орнуудад эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин эрэгтэйчүүдийнхээсээ доогуур байна.


ЗУРАГ 4.7. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, СОНГОСОН ОРНУУДААР, 2009 ОН



Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 15-24 насны нийт залуучуудын 3.7 хувь нь ямар нэг боловсролгүй байгаа ч эдгээр залуучуудын 58.9 хувь нь бичиг үсэг мэддэг байна. Сүүлийн 4 тооллогын дүнгээс харахад 1979, 1989, 2000 оны тооллогоор 15-19 насны бичиг үсэг мэдэгчдийн хувь 20-24 насныхнаас өндөр байсан бол 2010 оны тооллогоор 20-24 насны бичиг үсэг мэдэгчдийн хувь өндөр болсон байна.


¹⁰ "International Literacy Statistics: Review of Concepts, Methodology and Current Data", UNESCO, 2008

ЗУРАГ 4.8. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР




15-19 насны бичиг үсэг мэддэг эрэгтэйчүүдийн тоо 1979 оныхоос 1.1 дахин, 1989 оныхоос 2.2 дахин их байгаа ч 2000 оныхоос 2 дахин багассан бол 20-24 насны эрэгтэйчүүдийн хувьд 1979 оныхоос 4.8 дахин, 1989 оныхоос 4.5 дахин, 2000 оныхоос 1.6 дахин нэмэгдсэн байна. 15-19 насны бичиг үсэг мэддэг эмэгтэйчүүдийн тоо 1979 оныхоос 1.5 дахин, 2000 оныхоос 2.7 дахин бага, 1989 оныхоос 1.6 дахин их байгаа бол 20-24 насны бичиг үсэг мэддэг эмэгтэйчүүдийн тоо 1979 оныхоос 2.3 дахин, 1989 оныхоос 2.7 дахин, 2000 оныхоос 2.3 дахин их байна.

ЗУРАГ 4.9. БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Хүн ам, орон сууцны тооллогод боловсролгүй ч бичиг үсэг мэддэг гэж хариулсан 15-24 насны залуучуудын 69.6 хувь нь хөдөөд тоологдсон байгаа нь энэ насны бүлгийн хотод амьдардаг залуучуудын боловсролын түвшин хөдөөгийнхөөс өндөр, сургууль завсардалт хөдөөгийнхөөс харьцангуй бага, үргэлжлүүлэн суралцах боломж илүү зэрэг олон зүйлээс шалтгаалсан байж болох юм. Боловсролгүй ч бичиг үсэг мэддэг залуучуудын тоо нас ахих тутам нэмэгдэж байна.

ЗУРАГ 4.10. БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



4.3.2 СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ


Тооллого явагдаж байх үед сургуульд суралцаж байгааг тодорхойлохдоо цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг 2-5 насны хүүхдээс, албан ёсны боловсрол олгох сургуульд суралцаж байгаа эсэхийг 6-39 насны хүн амаас асуусан болно.

НҮБ-аас гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын удирдамж, зарчмууд”-ын 2.209-д “Сургуульд хамрагдалт нь тооллогын өдрүүдэд албан ёсны боловсрол олгох ямар нэг шатны сургуульд суралцаж байгаа тоолуулагчийн, хэрэв тооллого нь сургуулийн амралтын хугацаанд явагдсан бол тухайн хичээлийн жилийн төгсгөлд буюу өнгөрсөн хичээлийн жилийн турш суралцсан тоолуулагчаар тодорхойлогдоно. Боловсролын олон улсын стандарт ангилалд заасанчлан боловсрол гэдэгт хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн зориудын, системтэй бүхий л үйл ажиллагаануудыг багтаан ойлгоно. Тооллогын зорилгоор ямар нэг шатны боловсрол олгодоггүй сургалтад хамрагдагчдыг “сургуульд хамрагдалт” гэж үзэхгүй” гэж заажээ. Түүнчлэн дээрх зөвлөмжид сургуульд хамрагдалт “сургуульд элсэлт”-тэй харилцан бие биеэ нөхдөг үзүүлэлт ч гэлээ сургуульд элсэлтийг захиргааны мэдээллээс авдгаараа ялгардаг гэдгийг дурьджээ.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 15-24 насны 291.4 мянган залуучууд аль нэг шатны сургуульд суралцаж байгаа нь нийт тоологдсон энэ насны хүн амын 53.0 хувийг эзэлж байна. Сургуульд суралцдаг залуучуудын 46.1 хувь нь эрэгтэйчүүд, 53.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Сургуульд суралцаж буй залуучуудын тоо 19 наснаас эхлэн нас ахих тусам буурч байна.

ЗУРАГ 4.11. СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор 15 насны залуучуудын 72.8 хувь, 16-19 насныхны 40.0 хувь, 20-24 насныхны 15.6 хувь нь сургуульд хамрагдаж байсан бол 2010 оны тооллогоор 15 настнуудын 93.0 хувь, 16-19 насныхны 75.9 хувь, 20-24 насныхны 29.8 хувь нь сургуульд хамрагдаж байна.

ХҮСНЭГТ 4.5. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010 ОН									
15	93.0	90.5	95.6	95.8	94.7	96.9	88.2	83.5	93.1
16-19	75.9	69.6	82.5	82.9	78.9	86.8	54.4	45.2	66.8
20-24	29.8	25.8	33.8	37.3	33.5	40.9	6.2	5.1	7.6
2000 ОН									
15	72.8	65.7	80.0	87.6	83.5	91.5	53.5	44.2	64.0
16-19	40.0	33.2	47.0	57.0	49.6	63.9	15.5	11.8	19.8
20-24	15.6	12.3	19.0	26.0	20.9	30.8	1.7	1.5	1.9

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 168.4 мянган хүүхэд суурь боловсролд хамрагдаж байгаагийн 50.0 хувь нь хөвгүүд, 60.4 хувь хотод, 39.6 хувь нь хөдөө амьдарч байна.

Бүрэн дунд сургуульд болон МСҮТ-д 112.8 мянган залуучууд суралцаж байгаагийн 48.6 хувь нь эрэгтэйчүүд 51.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдгээр залуучуудын 71.3 хувь нь хотод, 28.7 хувь нь хөдөө амьдардаг залуучууд байна. Энэ нь суурь болон ахлах сургууль нийт 686, МСҮТ 63 ажиллаж байгаагийн талаас илүү нь хот сууринд төвлөрсөн байдагтай холбоотой юм. Нөгөө талаас хүмүүс хот, суурин руу шилжиж хүүхэддээ чанартай боловсрол эзэмшүүлэх гэсэн хүсэл ч мөн нөлөөлж байна.


ХҮСНЭГТ 4.6. СУУРЬ БОЛОН БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

	Суурь боловсролд хамрагдаж байгаа			Хүйсийн харьцаа	Бүрэн дунд болон МСҮТ-д суралцаж байгаа			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	168 505	84 308	84 197	100.1	112 781	54 801	57 980	94.5
Хот	101 731	50 725	51 006	99.4	80 463	39 643	40 820	97.1
Хөдөө	66 774	33 583	33 191	101.2	32 318	15 158	17 160	88.3

Боловсролын шатлал ахихад сургуульд хамрагдаж байгаа хөвгүүдийн тоо цөөрч охид давамгайлах хандлагатай болж байгаа бөгөөд энэ нь хот, хөдөөд ижил байна.

Тооллогод хамрагдсан 15-24 насны залуучуудын 96.3 хувь нь ямар нэг шатны боловсролтой гэж хариулсны 47.9 хувь нь бүрэн дунд боловсролтой, 25.3 хувь нь суурь боловсролтой, 13.4 хувь нь дээд боловсролтой байна. Хүйсээр авч үзвэл боловсролтой эрэгтэйчүүдийн 10.4 хувь нь дээд боловсролтой байгаа бол эмэгтэйчүүдийн 16.4 хувь нь дээд боловсролтой байгаа нь эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгааг харуулж байна.

ЗУРАГ 4.12. 15-24 НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН




15-24 насны залуучуудын боловсролын байдалд гарсан нэг өөрчлөлт бол дээд боловсролтой залуучуудын тоо 1979 оныхоос 11 дахин, 1989 оныхоос 7 дахин, 2000 оныхоос 4.8 дахин өссөн байна. Хүйсээр авч үзвэл, энэ насны дээд боловсролтой эрэгтэйчүүдийн тоо 2000 оныхоос 5.4 дахин, эмэгтэйчүүдийн тоо 4.5 дахин нэмэгджээ.

4.4. ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр гар утас хэрэглэдэг 15-24 насны 467.4 мянган залуучууд байгаагийн 48.7 хувь нь эрэгтэйчүүд, интернет хэрэглэдэг 292.5 мянган залуучуудын 46.6 хувь нь эрэгтэйчүүд байна. Гар утас хэрэглэгчдийн 55.0 хувь, интернет хэрэглэгчдийн талаас илүү нь буюу 52.9 нь 20-24 насны залуучууд байна. Гар утас, интернет хэрэглэгчдийн дотор эмэгтэйчүүдийн хувийн жин илүү байгаа нь эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс илүү байгаатай холбоотой байж болох юм.

ЗУРАГ 4.13. ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



Залуучуудын гар утасны хэрэглээг хот, хөдөөгөөр авч үзвэл гар утас хэрэглэгч залуучуудын 80.6 хувь нь хотод, 19.4 хувь нь хөдөөд тоологдсон нь хот сууринд амьдарч буй хүмүүст гар утас ашиглах боломж илүү байдагтай холбоотой юм.

ЗУРАГ 4.14. ГАР УТАС ХЭРЭГЛЭДЭГ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН




Гар утасны хэрэглээ хотод ч, хөдөөд ч, хүйсийн хувьд ч нас ахих тусам нэмэгдэж байна.

4.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУД

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагийн 2.6 хувь нь буюу 14.3 мянга нь 15-24 насны залуучууд эзэлж байна. Эдгээр залуучуудын 57.0 хувь нь эрэгтэйчүүд, 43.0 хувь нь эмэгтэйчүүд, насны хувьд 44.8 хувь нь 15-19 насны залуучууд эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын тал хувь нь сэтгэцийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй залуучууд байна.

ЗУРАГ 4.15. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН




Хөгжлийн бэрхшээлийн төрөлхийн болон олдмол гэсэн 2 төрөл байдаг бөгөөд ердийн өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн болон ахуйн осол зэрэг шалтгаануудын улмаас олдмол төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болдог.

Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 55.9 хувь төрөлхийн, 44.1 хувь олдмол төрлийн бэрхшээлтэй хүмүүс байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 21.9 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд эдгээр залуучуудын талаас илүү нь 20-24 насны залуучууд, хүйсийн хувьд 54.0 хувь нь эрэгтэйчүүд, 46.0 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын 54.1 хувь нь сэтгэцийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй байна.

ЗУРАГ 4.16. ТӨРӨЛХИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын 56.4 хувь нь хотод, 43.6 хувь нь хөдөөд тоологдсон бөгөөд талаас илүү нь сэтгэцийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс байна. Энэ нь хүйсийн хувьд ч, хот, хөдөөгөөр ч ялгаагүй манай залуучуудын дунд төрөлхийн энэ хэлбэрийн бэрхшээл зонхилж байгаа нь ажиглагдаж байна /Хүснэгт 4.7/.


ХҮСНЭГТ 4.7. ТӨРӨЛХИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Бэрхшээлийн хэлбэр	Бүгд		Хот			Хөдөө			
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	4 337	3 700	8 037	2 404	2 130	4 534	1 933	1 570	3 503
Харааны	558	477	1 035	287	279	566	271	198	469
Ярианы	577	415	992	306	224	530	271	191	462
Сонсголын	574	401	975	350	262	612	224	139	363
Хөдөлгөөний	906	946	1 852	554	562	1 116	352	384	736
Сэтгэцийн	1 370	1 130	2 500	698	588	1 286	672	542	1 214
Бусад	352	331	683	209	215	424	143	116	259

Түүнчлэн төрөлхийн сэтгэцийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй залуучуудын эзлэх хувь аль ч насанд зонхилох хувийг эзэлж байна.

Хөгжлийн олдмол бэрхшээлтэй залуучуудын 60.9 хувь нь эрэгтэйчүүд, 39.1 хувь нь эмэгтэйчүүд, насны хувьд талаас илүү буюу 58.8 хувийг 20-24 насны залуучууд эзэлж байна /Зураг 4.17/.

ЗУРАГ 4.17. ХӨГЖЛИЙН ОЛДМОЛ БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Хөгжлийн олдмол бэрхшээлтэй залуучуудын дунд хөдөлгөөний бэрхшээл хамгийн өндөр хувьтай байгаа бол харааны болон сэтгэцийн бэрхшээл хоёр, гуравдугаар зонхилох бэрхшээл болж байна. Хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд энэ байдал ижил байгаа ч эмэгтэйчүүдийн хувьд арай ялгаатай байгаа бөгөөд хөдөлгөөний бэрхшээл хамгийн өндөр хувьтай, сэтгэцийн болон харааны бэрхшээл хоёр, гуравдугаар зонхилох бэрхшээл болж байна. Хөгжлийн олдмол бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын 69.5 хувь нь хотод, 30.5 хувь нь хөдөөд тоологдсон байна /Хүснэгт 4.8/.

ХҮСНЭГТ 4.8. ХӨГЖЛИЙН ОЛДМОЛ БЭРХШЭЭЛТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Бэрхшээлийн хэлбэр	Бүгд		Хот			Хөдөө			
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	3 827	2 459	6 286	2 555	1 814	4 369	1 272	645	1 917
Ярианы	142	111	253	91	74	165	51	37	88
Сонголын	523	346	869	328	250	578	195	96	291
Хөдөлгөөний	1 130	544	1 674	745	410	1155	385	134	519
Сэтгэцийн	693	532	1 225	458	381	839	235	151	386
Бусад	634	397	1 031	436	296	732	198	101	299


Хотод тоологдсон хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 58.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд хөдөлгөөний бэрхшээл хамгийн өндөр хувьтай, харааны болон сэтгэцийн бэрхшээл хоёр, гуравдугаар зонхилох бэрхшээл болж байна. Энэ нь хүйсийн хувьд ялгаагүй байна.

Харин хөдөөгийн залуучуудын 66.4 хувь нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд хөдөлгөөний бэрхшээл мөн хамгийн өндөр хувьтай, сэтгэцийн болон харааны бэрхшээл хоёр, гуравдугаар зонхилох бэрхшээл болж байгаа нь хүйсийн хувьд мөн ялгаагүй байна. Түүнчлэн зонхилох хөгжлийн бэрхшээлийн хэлбэр насны хувьд ч ялгаагүй байна.

ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын 89.3 хувь нь огт гэр бүл болоогүй залуучууд байгаа бөгөөд тэдний 58.2 хувь эрэгтэйчүүд, 41.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 7.7 хувь батлуулсан гэр бүлтэй, 2.5 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй, 0.4 гэр бүл цуцалсан байна. Гэр бүлтэй залуучуудын дотор гэр бүлтэй эмэгтэйчүүд илүү байна.


ЗУРАГ 4.18. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, ХҮЙС, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, 2010 ОН



БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ


Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын 26.0 хувь нь боловсролгүй ч бичиг үсэг мэддэг бол 74.0 хувь нь бичиг үсгийн мэдлэггүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бичиг үсгийн мэдлэг нас ахих тусмаа нэмэгдэж байна.

ЗУРАГ 4.19. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВЬ, НАСААР, 2010 ОН



Хүйсийн хувьд бичиг үсэг мэддэг, мэддэггүй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ илүү байна.


ЗУРАГ 4.20. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2010 ОН



СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ


Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын 28.4 хувь нь сургуульд сурч байгаа, 71.6 хувь нь сургуульд сураагүй гэсэн хариулт өгчээ.

ЗУРАГ 4.21. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХУВЬ, НАС, ХҮЙСЭЭР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сургуульд хамрагдалт аль ч хүйсийн хувьд нас ахих тусам багасч байна. Энэ хандлага нь хот, хөдөөд ижил байна.


ЗУРАГ 4.22. СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН


Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 6.0 хувь нь дээд боловсролтой, 0.1 хувь магистр залуучууд байна.

ЗУРАГ 4.23. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын түвшинг хүйсээр авч үзвэл дээд боловсролтой хүмүүсийн хувь бараг ижил, тусгай мэргэжлийн дундаас доош бүх шатны боловсролтой хүмүүсийн хувьд эрэгтэйчүүд давамгайл байна.

ЗУРАГ 4.24. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, ХҮЙС, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, 2010 ОН



ТАВЛУГААР БҮЛЭГ

ЗАЛУУЧУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ



Тооллогод эдийн засгийн идэвхийг гаргахын тулд богино хугацаанд, долоо хоногт хамааралтай тухайн үеийн идэвх гэсэн аргыг хэрэглэсэн бөгөөд 15-аас дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг нь тусгасан юм.

5.1. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 15-24 насны 549.8 мянган залуучуудын 40.1 хувь нь эдийн засгийн идэвхтэй, тэдний хөдөлмөр эрхлэлтийн түвшин 67.3 хувь байна.

ХҮСНЭГТ 5.1. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	15-19	20-24	Бүгд	15-19	20-24	Бүгд	15-19	20-24
15-24 насны хүн ам - Бүгд	549 828	257 645	292 183	410 118	188 334	221 784	139 710	69 311	70 399
Эдийн засгийн идэвхитэй хүн ам - Бүгд	220 740	42 615	178 125	139 571	21 141	118 430	81 169	21 474	59 695
Ажил эрхэлдэг хүн амын тоо	148 523	25 631	122 892	91 564	10 905	80 659	56 959	14 726	42 233
Ажилгүйчүүд	72 217	16 984	55 233	48 007	10 236	37 771	24 210	6 748	17 462
Тохирох ажил олдохгүй байгаа	22 353	5 492	16 861	14 331	3 130	11 201	8 022	2 362	5 660
Ажил хайж байгаа	49 864	11 492	38 372	33 676	7 106	26 570	16 188	4 386	11 802
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	40.1	16.5	61.0	34.0	11.2	53.4	58.1	31.0	84.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	67.3	60.1	69.0	65.6	51.6	68.1	70.2	68.6	70.7

15-24 насны залуучуудын эдийн засгийн идэвхийг авч үзвэл насны хувьд 20-24 насны залуучуудын идэвх 15-19 насныхнаас илүү, эрэгтэйчүүдийнх эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь 15-24 насны суралцагчдын дунд эмэгтэйчүүд зонхилж байдагтай холбоотой юм.


ХҮСНЭГТ 5.2. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

	Эдийн засгийн идэвхтэй хүн ам						Эдийн засгийн идэвхгүй хүн ам					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*
БҮГД	198.4	36.1	120.3	43.3	78.1	28.7	351.4	63.9	157.8	56.7	193.6	71.3
15-19	37.1	14.4	25.9	19.8	11.2	8.8	220.5	85.6	104.7	80.2	115.8	91.2
20-24	161.3	55.2	94.4	64.0	66.9	46.2	130.9	44.8	53.1	36.0	77.8	53.8

* тухайн насны бүлгийн хүн амд эзлэх хувь

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 15-24 насны залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин 2000 оны тооллогынхоос буурсны дотор 15-19 настай хүн амынх 24.7, 20-24 настай залуучуудынх 6.7 хувиар буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшинг хүйсээр авч үзэхэд ч мөн өмнөх тооллогынхоос буурсан байна. Энэ нь 15-24 насны залуучуудын сургуульд хамрагдалт нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм.

ЗУРАГ 5.1. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН



5.2. АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 15-24 насны 49.9 мянган хүн хөдөлмөр эрхэлдэг гэсэн дүн гарсны 57.8 хувь нь эрэгтэйчүүд, 42.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдгээр залуучуудын 23.0 хувь нь 15-19 насныхан, 77.0 хувь нь 20-24 насныхан байна.

ХҮСНЭГТ 5.3. 15-24 НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЗАЛУУЧУУД, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	тоо	хувь*	тоо	хувь*	тоо	хувь*
БҮГД	49 864	9.1	33 676	8.2	16 188	11.6
Эрэгтэй	28 826	10.4	19 209	9.6	9 617	12.3
Эмэгтэй	21 038	7.7	14 467	6.9	6 571	10.7

* тухайн насны бүлгийн хүн амд эзлэх хувь

Тооллогод хөдөлмөр эрхэлдэг гэж хариулсан 15-24 насны залуучуудын 67.5 хувь нь хотод байгаа нь хотод оршин сууж буй залуучууд ажил эрхлэх боломжоороо хөдөө амьдардаг залуучуудаас илүү байдагтай холбоотой байж болох юм.

Хөдөлмөр эрхэлдэг 15-24 насны залуучуудын 57.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Хөдөлмөр эрхэлдэг залуучуудын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа хандлага хот, хөдөөд ч мөн ижил байна.

ХҮСНЭГТ 5.4. 15-24 НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Мян.хүн

	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	49.9	28.8	21.0	33.7	22.2	14.5	16.2	9.6	6.5
15-19	11.5	7.2	4.3	7.1	4.4	2.7	4.4	2.7	1.6
20-24	38.4	21.6	16.7	26.6	17.8	11.8	11.8	6.9	4.9

Ажил эрхэлдэг залуучуудын тоо өмнөх тооллогын дүнгээс буурсан байгаа нь залуучуудын сургуульд хамрагдалт нэмэгдсэн, аж ахуйн нэгж байгууллагууд ажлын дадлага туршлагатай, ажил гүйцэтгэх чадвар сайтай, бүтээмж өндөртэй хүмүүсийг ажиллуулах сонирхол нэмэгдэж байгаа зэрэг шалтгаанаас гадна өнгөрсөн жилүүдэд ажиллаж байсан энэ насны хүмүүс нас дэвшсэнтэй холбоотой юм /Хүснэгт 5.5/.

ХҮСНЭГТ 5.5. 15-24 НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

Мян.хүн

Насны бүлэг	2000			2010			2010 2000 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	207.0	117.5	89.5	148.5	91.4	57.1	71.7
15-19	80.9	48.4	32.5	25.6	18.7	6.9	31.6
20-24	126.1	69.1	57.0	122.9	72.7	50.2	97.5

Ажил эрхэлдэг залуучуудын 61.6 хувь нь хотод тоологдсон, 38.4 хувь нь хөдөөд тоологдсон байна. Хотын залуучууд голчлон бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж байгаа бол хөдөөгийн залуучуудын дийлэнх нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5.6. АЖИЛ ЭРХЭЛДЭГ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, 2010 ОН

Мян.хүн

	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	15-19	20-24	Бүгд	15-19	20-24	Бүгд	15-19	20-24
БҮГД	148.5	25.6	122.9	91.6	10.9	80.7	57.0	14.7	42.2
ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт	39.5	11.0	28.5	2.9	0.8	2.1	36.6	10.2	26.4
Уул уурхай, олборлолт	8.5	1.0	7.5	4.9	0.4	4.5	3.6	0.6	3.0
Боловсруулах үйлдвэрлэл	11.9	1.6	10.3	11.1	1.4	9.6	0.9	0.2	0.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.7	0.1	1.6	1.5	0.1	1.4	0.3	0.0	0.2
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	0.6	0.1	0.5	0.5	0.1	0.5	0.1	0.0	0.1
Барилга	12.0	1.8	10.2	10.3	1.4	8.8	1.7	0.3	1.4
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	16.6	1.8	14.9	15.5	1.6	13.9	1.1	0.2	1.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.9	0.4	5.4	5.0	0.4	4.7	0.8	0.1	0.8
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	8.0	1.6	6.3	7.4	1.5	5.9	0.6	0.2	0.4
Мэдээлэл, холбоо	3.3	0.1	3.1	3.2	0.1	3.1	0.1	0.0	0.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3.1	0.0	3.1	2.5	0.0	2.5	0.6	0.0	0.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.8	0.1	0.7	0.8	0.1	0.7	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.5	0.1	1.4	1.3	0.0	1.3	0.2	0.0	0.1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.6	0.3	2.2	2.2	0.3	1.9	0.4	0.1	0.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	16.2	4.6	11.6	9.9	1.9	8.0	6.3	2.7	3.6
Боловсрол	7.7	0.2	7.5	5.2	0.1	5.1	2.5	0.0	2.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.1	0.1	3.0	2.3	0.1	2.2	0.8	0.0	0.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.5	0.2	1.3	1.4	0.2	1.2	0.1	0.0	0.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3.5	0.5	3.0	3.3	0.4	2.9	0.2	0.1	0.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.2	0.1	0.1	0.2	0.0	0.1	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.3	0.0	0.3	0.3	0.0	0.3	0.0	0.0	0.0


Ажил эрхэлдэг залуучуудын 61.5 хувь нь эрэгтэйчүүд, 38.5 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд эрэгтэйчүүд голчлон хөдөө аж ахуй, барилга, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаанд, эмэгтэйчүүд ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт, бөөний болон жижиглэн худалдаа, байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаанд ихэвчлэн ажиллаж байна.

ХҮСНЭГТ 5.7. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, ХҮЙС, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, 2010 ОН

Ажил эрхэлдэг хүн ам	Бүгд		Хүйсийн бүтэц, %		Дүнд эзлэх хувь		
	Эрэгтэй мян.хүн	Эмэгтэй мян.хүн	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	148.5	91.4	57.1	61.5	38.5	100.0	100.0
Хаа, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт	39.5	25.0	14.4	63.4	36.6	27.4	25.3
Уул уурхай, олборлолт	8.5	7.1	1.4	83.5	16.5	7.8	2.5
Боловсруулах үйлдвэрлэл	11.9	6.8	5.1	57.3	42.7	7.5	8.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.7	1.5	0.3	83.8	16.2	1.6	0.5
Усан хангамж	0.6	0.4	0.2	72.7	27.3	0.5	0.3
Барилга	12.0	10.2	1.8	84.8	15.2	11.1	3.2
Бөөний, жижиглэн худалдаа	16.6	7.8	8.9	46.8	53.2	8.5	15.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.9	4.9	1.0	83.7	16.3	5.4	1.7
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	8.0	2.1	5.9	26.3	73.7	2.3	10.3
Мэдээлэл, холбоо	3.3	1.8	1.4	55.8	44.2	2.0	2.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3.1	1.2	1.9	40.0	60.0	1.4	3.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.8	0.5	0.4	58.1	41.9	0.5	0.6
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.5	0.7	0.8	48.3	51.7	0.8	1.3
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.6	1.9	0.7	73.3	26.7	2.1	1.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	16.2	14.1	2.1	86.9	13.1	15.4	3.7
Боловсрол	7.7	2.1	5.6	27.8	72.2	2.3	9.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.1	0.7	2.4	22.3	77.7	0.8	4.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2.2	1.5	0.7	70.1	29.9	1.7	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.0	0.0	2.0	0.8	99.2	0.0	3.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн үйлчилгээ	0.3	0.1	0.2	41.5	58.5	0.1	0.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.2	0.0	0.2	5.0	95.0	0.0	0.4


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод ажил эрхэлдэг гэж хариулсан 15-24 насны залуучуудын ажил эрхлэлтийн байдал (статус)-ыг авч үзвэл, 15-19 насны залуучуудын 51.0 хувь нь цалин хөлстэй ажил эрхэлдэг, 37.0 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байгаа бол 20-24 насныхны хувьд 66.0 хувь цалин хөлстэй ажил эрхэлдэг, 1.0 хувь нь ажил олгогч, 17.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

ЗУРАГ 5.2. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР, 2010 ОН




Ажил эрхэлдэг залуучуудын 6.6 хувь нь ямар нэг шатны боловсролгүй залуучууд байгаагийн 67.6 хувь нь бичиг үсэг мэддэг, 32.4 хувь нь бичиг үсэг мэддэггүй, хотод тоологдсон ажил эрхэлдэг залуучуудын 1.6 хувь, хөдөөд тоологдсон залуучуудын 14.6 хувь нь боловсролгүй залуучууд байна. Бичиг үсэг мэддэг залуучуудын 32.6 хувийг 15-19 насны залуучууд, 67.4 хувийг 20-24 насныхан эзэлж байна. Ажил эрхэлдэг 15-24 насны залуучуудын 34.6 хувь нь бүрэн дунд, 14.1 хувь нь суурь, 26.5 хувь нь дээд боловсролтой байна.

ЗУРАГ 5.3. АЖИЛ ЭРХЭЛДЭГ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, 2010 ОН




Хотод ажиллаж байгаа 15-24 насны залуучуудын дунд дээд боловсролтой, бүрэн дунд боловсролтой залуучууд дийлэнх хувийг эзэлж байгаа бол хөдөөд ажиллаж байгаа залуучуудын дийлэнх нь бүрэн дундаас доош боловсролтой байгаагаас дээр дурьдсанчлан хөдөө ажиллаж буй залуучууд гол төлөв мал аж ахуйн салбарт ажиллаж, өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцож байна.

ЗУРАГ 5.4. ЗАЛУУЧУУДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



Ажил эрхэлдэг залуучуудын 64.7 хувь нь огт гэрлээгүй бол 34.6 хувь нь гэр бүлтэй залуучууд байна.

ЗУРАГ 5.5. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЗАЛУУЧУУД, ХУВИАР, НАСНЫ БҮЛЭГ, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, 2010 ОН



Ажил эрхэлдэг 15-24 насны эрэгтэйчүүдийн 70.1 хувь нь, эмэгтэйчүүдийн 56.0 хувь нь огт гэрлээгүй байна. Энэ насны эрэгтэйчүүдийн 29.5 хувь нь, эмэгтэйчүүдийн 42.9 хувь нь гэр бүлтэй байна. Тооллогод тоологдсон 15-24 насны огт гэр бүл болоогүй нийт залуучуудын 21.8 хувь, гэр бүлтэй залуучуудын 48.1 хувь нь ажил эрхэлж байна. Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн 27.3 хувь, эмэгтэйчүүдийн 15.5 хувь, гэр бүлтэй эрэгтэйчүүдийн 63.2 хувь, эмэгтэйчүүдийн 38.0 хувь нь ажил эрхэлж байна.


ХҮСНЭГТ 5.8. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан гэр бүлтэй	Батлуулаагүй гэр бүлтэй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлбэсэн
БҮГД	148 523	96 084	40 013	11 386	586	348	106
15-19	25 631	23 949	846	805	25	3	3
20-24	122 892	72 135	39 167	10 581	561	345	103
ЭРЭГТЭЙ - БҮГД	91 413	64 091	20 066	6 859	252	126	19
15-19	18 684	18 051	253	361	18	1	0
20-24	72 729	46 040	19 813	6 498	234	125	19
ЭМЭГТЭЙ - Бүгд	57 110	31 993	19 947	4 527	334	222	87
15-19	6 947	5 898	593	444	7	2	3
20-24	50 163	26 095	19 354	4 083	327	220	84

Түүнчлэн хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ сургуульд сурдаг гэж хариулсан 15-24 насны 5.4 мянган залуучууд байгаа нь энэ насны ажил эрхэлдэг залуучуудын 3.6 хувийг эзэлж байна. Эдгээр залуучуудын 20.3 хувь нь 15-19 насныхан, 79.7 хувь нь 20-24 насныхан, 57.3 хувь нь эрэгтэйчүүд, 42.7 хувь нь эмэгтэйчүүд байна.


Хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ сургуульд сурдаг залуучуудын тоо 18 наснаас дээш нас ахих тусам нэмэгдэж байгаа бөгөөд энэ байдал хүйсийн хувьд ижил байна.

ЗУРАГ 5.6. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ СУРГУУЛЬД СУРДАГ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



Хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ сургуульд сурдаг залуучуудын тоо хотод хөдөөгийнхөөс илүү байна. Хөдөөд ажил эрхлэхийн зэрэгцээгээр сурдаг гэж хариулсан 15-17 насны охид хөвгүүд хотынхоос олон байна.

ЗУРАГ 5.7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ СУРГУУЛЬД СУРДАГ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН




Ажил эрхэлдэг 15-24 насны залуучуудын 1.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй залуучууд байгаагийн 24.8 хувь нь 15-19 насныхан, 75.2 хувь нь 20-24 насныхан байна. Ажил эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дийлэнх нь цалин хөлстэй ажиллагч, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцдог залуучууд байна. 20-24 насныхан дунд хувиараа хөдөлмөр эрхлэгчид нэлээд хувийг эзэлж байна.

ЗУРАГ 5.8. АЖИЛ ЭРХЭЛДЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР, 2010 ОН



Ажил эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй 15-19 насны хотод амьдардаг залуучуудын хувьд цалин хөлстэй ажил эрхлэх боломж хөдөөгийнхөөс арай илүү байгаа бол энэ насны хөдөө амьдардаг залуучуудын дийлэнх нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцож байна. 20-24 насныхны хувьд ч мөн хотод цалин хөлстэй ажил эрхлэх боломж илүү, хөдөөд амьдардаг залуучуудын дийлэнх нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцож, цөөн хэсэг нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дотор хөдөөгийнхний эзлэх хувь арай өндөр байна.

ЗУРАГ 5.9. АЖИЛ ЭРХЭЛДЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТАТУС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



5.3. АЖИЛГҮЙ ЗАЛУУЧУУД

2009 оны байдлаар дэлхийн 207 сая хүн ажилгүй байсны 40 хувь орчим буюу 81 сая орчим нь 15-24 насны залуучууд байна. Залуучуудын ажилгүйдлийн түвшин эдийн засгийн хямралаас үүдэн 2008 онд 11.8 байснаа 12.7 хувь болж өссөн ч 2010 оноос бага зэрэг дээрдэх төлөв ажиглагдаж байна¹¹.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 72.2 мянган 15-24 насны залуучууд ажилгүй гэсэн хариулт өгсний 58.1 хувь нь эрэгтэйчүүд, 41.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Залуучуудын ажилгүйдлийн түвшин 2000 оныхоос нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5.9. АЖИЛГҮЙ ЗАЛУУЧУУД, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2000 ОН									
БҮГД	22.8	22.7	23.0	24.4	26.0	22.4	10.2	10.2	10.3
15-19	25.5	24.4	27.2	48.7	47.1	51.0	13.7	12.5	15.3
20-24	21.0	21.5	20.4	32.8	33.5	31.8	11.2	11.0	11.4
2010 ОН									
БҮГД	25.1	24.0	26.9	26.9	26.2	27.9	22.1	20.5	24.9
15-19	31.0	27.8	38.2	39.5	37.7	42.9	22.9	19.5	32.5
20-24	23.8	22.9	25.0	24.8	24.0	25.9	21.8	21.0	23.2


Ажилгүй залуучуудын 31.0 хувь нь тохирох ажил олдохгүй байгаа гэсэн хариулт өгсөн байна. Сүүлийн 10 жилд буюу 2 тооллогын хооронд гарсан нэг өөрчлөлт бол тохирох ажил олдохгүйгээс ажилгүй байгаа залуучуудын тоо буурсан бөгөөд энэ байдал хот, хөдөөд адил байгаа ч хөдөөд амьдарч байгаа тохирох ажил олдохгүйгээс ажилгүй байгаа 20-24 насны залуучуудын тоо нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5.10. ТОХИРОХ АЖИЛ ОЛДОХГҮЙГЭЭС АЖИЛГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	29 656	20 910	8 746	22 353	14 331	8 022
15-19	13 804	9 169	4 635	5 492	3 130	2 362
20-24	15 852	11 741	4 111	16 861	11 201	5 660

Тохирох ажил олдохгүй гэсэн шалтгаанаар ажилгүй байгаа залуучуудын 61.1 хувь нь нийслэл, аймгийн төвүүдэд амьдарч байгаа нь нэг талаас дотоод шилжих хөдөлгөөн, залуучуудын төв суурин газар амьдарч, ажиллах хүсэл тэмүүлэл зэрэгтэй холбоотой байж болох юм. Мөн хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа ч нөлөөлж байна.

¹¹ ILO: Global employment trends for youth: 2011 update

**ЗУРАГ 5.10. ТОХИРОХ АЖИЛ ОЛДОХГҮЙГЭЭС АЖИЛГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУД,
НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШЛААР, 2010 ОН**


Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үед ажилгүй байсан ч ажил идэвхтэй хайж байгаа 15-24 насны 49.9 мянган залуучууд байгаагийн 57.8 хувь нь эрэгтэйчүүд, 42.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажил хайж байгаа залуучуудын тоо 2000 оны тооллогынхоос буурсан нь 15-24 насны залуучуудын сургуульд хамрагдалт нэмэгдсэнтэй холбоотой юм.

**ХҮСНЭГТ 5.11. АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ТОО,
НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН**

Насны бүлэг	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	61 258	34 476	26 782	49 864	28 826	21 038
15-19	27 745	15 593	12 152	11 492	7 193	4 299
20-24	33 513	18 883	14 630	38 372	21 633	16 739


Ажил хайж байгаа гэж хариулсан залуучуудын 67.5 хувь нь хотод тоологдсон байна. Хот, хөдөөд тоологдсон 20-24 насны ажил хайж байгаа залуучуудын тоо өмнөх тооллогынхоос нэмэгдсэн байна.

**ХҮСНЭГТ 5.12. АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ТОО,
НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН**

Насны бүлэг	2000			2010		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	61 258	41 672	19 586	49 864	33 676	16 188
15-19	27 745	17 907	9 838	11 492	7 106	4 386
20-24	33 513	23 765	9 748	38 372	26 570	11 802

Ажил хайж байгаа залуучуудын 70.6 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой, 52.4 хувь нь эрэгтэйчүүд, 47.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 5.11. АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ЗАЛУУЧУУД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, 2010 ОН




Ажил хайж байгаа ямар нэг шатны боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин 25.5 байхад боловсролгүй залуучуудынх 18.9 байна. Түүнчлэн ажил хайж байгаа боловсролтой эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Энэ нь сүүлийн жилүүдэд дээд боловсрол эзэмшигчдийн болон мэргэжил, үйлдвэрлэл сургалтын төвд элсэгчдийн тоо тогтмол өсч, залуучуудын сургуульд хамрагдалт, боловсролын түвшин дээшилж байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, сургуулиудын мэргэжлийн чиглэл шинэ тутам хөгжиж байгаа бизнесийн салбар, чиглэлүүдтэй уялдахгүй байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 5.13. АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
АЖИЛ ХАЙЖ БАЙГАА, МЯН.ХҮН								
БҮГД	49.9	10.9	1.4	2.5	20.4	8.5	3.9	2.3
15-19	11.5	0.1	0.3	0.9	5.0	3.1	1.3	0.8
20-24	38.4	10.8	1.1	1.6	15.4	5.4	2.6	1.5
ЭРЭГТЭЙ - БҮГД	28.8	3.9	0.8	1.5	12.3	5.9	2.8	1.7
15-19	7.2	0.0	0.2	0.5	2.9	2.1	0.9	0.6
20-24	21.6	3.9	0.6	1.0	9.4	3.8	1.9	1.1
ЭМЭГТЭЙ - БҮГД	21	6.9	0.7	1.1	8.1	2.6	1.1	0.5
15-19	4.3	0.0	0.2	0.4	2.1	1.0	0.4	0.2
20-24	16.7	6.9	0.5	0.7	6.0	1.6	0.7	0.3
АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ								
БҮГД	25.1	21.3	19.2	31.2	28.4	28.9	20.8	18.9
15-19	31.0	27.5	24.1	39.1	36.0	33.0	23.0	18.9
20-24	23.8	21.3	18.2	28.1	26.6	26.9	19.9	18.9
ЭРЭГТЭЙ - БҮГД	24.0	18.1	15.7	28.6	27.1	28.1	20.8	19.1
15-19	27.8	25.4	17.2	34.8	33.0	30.3	21.3	17.5
20-24	22.9	18.1	15.4	26.3	25.7	26.9	20.6	20.0
ЭМЭГТЭЙ - БҮГД	26.9	23.6	25.6	35.4	30.6	30.9	20.8	18.4
15-19	38.2	29.8	39.4	45.6	41.1	40.8	29.2	23.2
20-24	25.0	23.6	23.0	31.2	28.2	26.9	18.2	16.0

Хотод тоологдсон ажил хайж байгаа залуучуудын хувьд боловсролгүй залуучуудад ажлын байр олдох боломж хомс учраас боловсролгүй залуучуудын ажилгүйдлийн түвшин бусдаас өндөр байгаа бол хөдөөд эсрэгээрээ бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хөдөөд ажлын байр хомс байдагтай холбоотой юм.


ЗУРАГ 5.12. АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙС, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН



5.4. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ЗАЛУУЧУУД


Эдийн засгийн идэвхгүй хүн амд тооллогын өмнөх 7 хоногт сургуульд сурдаг, тэтгэвэр, нөхөн олговорт байдаг, хөдөлмөрлөх чадваргүй, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүй зэрэг шалтгааны улмаас ажил эрхлээгүй хүн амыг хамааруулав. 15-24 насны залуучуудын 87.0 хувь нь сургуульд сурдаг, 2.0 хувь нь хөдөлмөрлөх чадваргүй учир ажил эрхэлдэггүй байна.

ЗУРАГ 5.13. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ЗАЛУУЧУУД, ХУВИАР, ШАЛТГААНААР, 2010 ОН




Эдийн засгийн идэвхгүй 351.7 мянган залуучуудын 62.8 хувь нь 15-19 насныхан, 37.2 хувь нь 20-24 насны залуучууд байна. 15-19 насныхны хувьд дийлэнх нь сургуульд сурдаг бол 20-24 насныхны хувьд сургуульд сурдагас гадна гэрийн ажилтай, тохирох ажил олдохгүй гэсэн шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна.

ЗУРАГ 5.14. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ЗАЛУУЧУУД, НАСНЫ БҮЛЭГ, ШАЛТГААНААР, 2010 ОН




Эдийн засгийн идэвхгүй залуучуудын тодорхой хэсгийг ажиллах сонирхолгүй гэж хариулсан залуучууд эзэлж байгаа бөгөөд тэдний дийлэнх 57.1 хувь нь 20-24 насныхан, 66.8 хувь нь эрэгтэйчүүд байна.

ЗУРАГ 5.15. АЖИЛЛАХ СОНИРХОЛГҮЙ ЗАЛУУЧУУДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БҮС НУТГИЙН БОЛОН АЙМГУУДЫН ЯЛГАА



6.1. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд бүсчилсэн хөгжлийн нийгэм, соёлын хүрээний нэг үндэслэл нь хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, сурч боловсрох, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх, мэдээлэл авах эрх чөлөө эдлэх, аймаг, орон нутгийнхаа амьдралд идэвхтэй, эрх тэгш хамтран оролцох, улмаар хөдөөгийн хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, мэдээлэл, ахуйн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлж, бүс нутгийн харьцангуй жигд хөгжлийг хангах нөхцлийг бүрдүүлэхэд оршдог. Мөн уг үзэл баримтлалд “бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлнэ” гэж заасан байдаг.

Аймаг, орон нутагт сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд болон бусад төрийн үйлчилгээний бодлого, төлөвлөлт хийхэд шаардлагатай байдаг үзүүлэлтийн нэг нь хүүхэд, залуучуудын тоо юм.

2010 оны 11 сарын байдлаар Монгол Улсад 0-24 насны нийт 1291.4 мянган хүүхэд, залуучууд байгаагаас 452.1 мянга нь Улаанбаатар хотод, 249.7 мянга нь Хангай, 206.3 мянга нь Төв, 184.2 мянга нь Баруун, 88.2 мянга нь Зүүн бүсэд амьдарч байв.


ХҮСНЭГТ 6.1. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, БҮСЭЭР, 2010 ОН

Бүс	0-24 насны хүн ам - Бүгд	Насны бүлэг				
		0-4	5-9	10-14	15-19	20-24
БҮГД	1 291 404	288 497	216 214	236 865	257 645	292 183
Баруун	184 156	43 012	37 432	40 990	34 829	27 893
Хангай	249 656	57 435	45 740	54 211	46 903	45 367
Төв	206 295	47 631	36 511	40 902	38 585	42 666
Зүүн	88 205	20 782	16 491	18 009	16 309	16 614
Улаанбаатар	563 092	119 637	80 040	82 753	121 019	159 643

Тухайн бүсийн нийт хүн амд эзлэх 0-14 насны хүүхдийн хувийн жинг бүсээр авч үзэхэд Баруун бүсийнх хамгийн өндөр (34.4 хувь) байгаа нь Баруун бүсэд төрөлтийн түвшин өндөр хэвээр байгаатай холбоотой юм. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн бага (24.5 хувь) байна.


15-24 насны залуучуудын хувийн жин Улаанбаатараас бусад бүсэд ойролцоо буюу 17.8-18.4 хувь байхад Улаанбаатар хотод 24.5 хувьтай байгаа нь хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, их дээд, сургууль, МСҮТ нийслэлд төвлөрсөн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

ЗУРАГ 6.1. НИЙТ ХҮН АМД ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, БҮСЭЭР, 2010 ОН



15-24 насны залуучуудын хүйсийн харьцаа улсын хэмжээнд 100 эмэгтэйд 102.3 эрэгтэй ногдож байна. Хүйсийн харьцаа Улаанбаатар хотод 100-аас бага буюу 100 эмэгтэйд 93.8 эрэгтэй ногдож байна. Архангай, Ховд аймгаас бусад бүх аймгийн хувьд залуучуудын хүйсийн харьцаа улсын түвшнээс өндөр байгаа нь хөдөө орон нутагт залуу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү тоологдсоныг харуулж байна. Тэр дундаа Өмнөговь аймагт залуучуудын хүйсийн харьцаа 150.2 байгаа нь уг аймагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад залуу эрэгтэйчүүд их ажилладагтай холбоотой юм.

ЗУРАГ 6.2. 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, АЙМГААР, 2010 ОН




6.2. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН БОЛОВСРОЛ

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжиж тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан боловсрол, шинжлэх ухааны шинэ хэв шинж бүхий тогтолцоо бүрдүүлэхээр заасан байдаг.

Бага боловсролын шатны сургуульд суралцагчдын хувь Хэнтий, Сүхбаатар, Говь-Алтай аймагт 90-ээс дээш хувьтай, Архангай, Булган аймгийн хувьд 6-10 насны 10 хүүхэд тутмын 8 нь бага боловсролын шатны сургуульд суралцаж байна /Зураг 6.3/.


ЗУРАГ 6.3. БАГА БОЛОВСРОЛЫН ШАТНЫ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, ХУВИАР, 2010 ОН



Улсын хэмжээнд 6-15 насны нийт хүүхдийн 3.6 хувь нь сургуулиас завсардсаныг бүсээр авч үзвэл Баруун бүсэд хамгийн их буюу 5.4 хувь, Хангайн бүсэд 4.7 хувь, Зүүн бүсэд 3.4 хувь, Төвийн бүсэд 2.9 хувь, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 2.4 хувь байна.


Улаанбаатараас бусад бүсэд сургууль завсардсан хүүхдүүдийн хүйсийн харьцаа 160-аас их байгаа нь хөдөө орон нутагт суурь боловсрол эзэмших насандаа сургууль завсардаж байгаа хүүхдүүдийн дотор хөвгүүд дийлэнх хэвээр байгааг харуулж байна.

ЗУРАГ 6.4. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮҮХДИЙН ТУХАЙН НАСНЫ НИЙТ ХҮҮХДЭД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, БҮСЭЭР, 2010 ОН



Баруун бүсэд сургууль завсардалт өндөр байгаа нь Ховд (4.2 хувь), Увс (5.8 хувь), Баян-Өлгий (8.5 хувь) аймагт 6-15 насны хүүхдийн сургууль завсардалт их байгаатай холбоотой юм.


ЗУРАГ 6.5. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮҮХЭД, ТУХАЙН НАСНЫ НИЙТ ХҮҮХДЭД ЭЗЛЭХ ХУВИАР, АЙМАГ, ХУВИАР, 2010 ОН



6.3. ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ


Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй 15-24 насны залуучуудын 41.8 хувь нь Улаанбаатар хотод, 21.1 хувь нь Хангай, 17.0 хувь нь Төв, 12.3 хувь нь Баруун, 7.8 хувь нь Зүүн бүсэд амьдардаг байна.

ЗУРАГ 6.6. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУД, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, БҮСЭЭР, 2010 ОН




Эдийн засгийн идэвхтэй 3 залуу тутмын 2 нь хөдөлмөр эрхэлдэг байна. Хөдөлмөр эрхэлдэг залуучуудыг аймгаар авч үзэхэд Өмнөговь аймгийн 15-24 насны 4 залуу тутмын 3 нь хөдөлмөр эрхэлдэг байхад Баян-Өлгий аймагт ердөө 2 залуу тутмын 1 нь л хөдөлмөр эрхэлдэг байна.

ЗУРАГ 6.7. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУД, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХЭЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН




Эдийн засгийн идэвхтэй залуучуудыг хөдөлмөр эрхэлдэг эсэхээр нь нас, хүйсээр Зураг 6.8-д үзүүлэв. Уг зургаас харахад аль ч аймагт хөдөлмөр эрхэлж буй залуу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ илүү байна. Тэр дундаа Баян-Өлгий аймагт хөдөлмөр эрхэлдэггүй залуу эмэгтэйчүүд их байна.

ЗУРАГ 6.8. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУД, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХЭЭР, НАС, ХҮЙСЭЭР, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН



Хөдөлмөр эрхэлдэг 15-24 насны залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд цалин хөлстэй ажиллагч Улаанбаатар хотод (83.9 хувь), хувиараа хөдөлмөр эрхэлдэг болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцдог залуучууд Баруун болон Хангайн бүсэд хамгийн их байна.

ЗУРАГ 6.9. 15-24 НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЗАЛУУЧУУД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, БҮСЭЭР, 2010 ОН



Эдийн засгийн идэвхгүй залуучуудын хувийн жин аймгуудад 70-85 хувьтай байгаа бөгөөд ажиллах сонирхолгүй залуучуудынх 0.1-0.4 хувьтай байгаа юм. Дундговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад хөдөлмөр эрхлэх чадваргүй залуучуудын хувь улсын дунджаас 2.2-2.3 дахин их байгааг нарийвчлан судлах хэрэгтэй юм. Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн 15-24 насны 10 залуу тутмын 1 нь тохирох ажил олдохгүй байгаа гэж хариулсан байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээрх мэргэжлийн эрэлт хэрэгцээг нарийвчлан судлах, мэргэжилтэн бэлтгэж байгаа чиглэлийг үүнтэй уялдуулах шаардлагатайг харуулж байна.

ХҮСНЭГТ 6.2. 15-24 НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ЗАЛУУЧУУД, НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ШАЛТГААН, АЙМГААР, 2010 ОН

	Эдийн засгийн идэвхигүй залуучууд - Бүгд	Сургуульд сурдаг	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
БҮГД	100.0	81.8	2.0	6.4	6.4	0.2	3.2
Архангай	100.0	80.8	2.8	5.0	7.9	0.3	3.2
Баян-Өлгий	100.0	76.2	2.5	6.3	11.6	0.3	3.2
Баянхонгор	100.0	73.5	3.9	5.7	14.0	0.2	2.8
Булган	100.0	77.1	3.2	6.4	8.1	0.3	4.9
Говь-Алтай	100.0	77.9	2.8	3.3	13.5	0.1	2.4
Дорноговь	100.0	74.6	2.9	9.2	6.7	0.4	6.1
Дорнод	100.0	70.9	3.3	8.8	11.6	0.5	4.9
Дундговь	100.0	79.7	4.5	5.7	5.7	0.2	4.2
Завхан	100.0	81.3	2.7	4.4	8.2	0.1	3.3
Өвөрхангай	100.0	75.3	3.0	7.8	8.8	0.3	4.7
Өмнөговь	100.0	71.5	3.3	11.6	7.1	0.3	6.1
Сүхбаатар	100.0	70.9	4.4	6.4	11.3	0.2	6.8
Сэлэнгэ	100.0	72.6	3.7	9.2	9.9	0.1	4.5
Төв	100.0	74.9	2.9	8.5	8.5	0.2	5.0
Увс	100.0	81.3	3.2	3.4	9.9	0.2	2.0
Ховд	100.0	82.8	2.2	4.3	8.4	0.2	2.1
Хөвсгөл	100.0	70.2	4.6	8.0	12.0	0.3	4.9
Хэнтий	100.0	70.7	3.9	8.8	10.4	0.3	5.9
Дархан-Уул	100.0	87.2	1.5	5.1	4.6	0.1	1.5
Улаанбаатар	100.0	85.5	1.2	6.1	4.1	0.2	2.9
Орхон	100.0	80.7	2.2	7.7	8.1	0.1	1.1
Говьсүмбэр	100.0	79.8	2.9	8.6	5.9	0.4	2.3

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 0-24 насны 1332.3 мянган хүүхэд, залуучууд байна.

2000-2010 оны хооронд 0-14 насны хүүхдийн тоо 1.1 хувиар буурсан бол 15-24 насны залуучуудын тоо 1.6 хувиар өссөн байна. Нийт хүн амын дунд залуу буюу 0-15 насны хүн амын эзлэх хувь нь 35 ба түүнээс дээш бол тухайн улсыг залуу хүн амтай улс гэж үздэг. Манай улсын нийт хүн амд 15 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь 1956-1969 онуудад 30.4-44.5 байсан бол 1979 оноос буурсаар 2010 онд 28.0 хувь боллоо.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор хөдөөд тоологдсон 15-24 насны залуучуудын тоо өмнөх тооллогынхоос багасч, хотод амьдарч буй энэ насны залуучуудын тоо нэмэгдсэн байна. 0-24 насны хүүхэд, залуучуудын 44.0 хувь нийслэлд, 21.0 хувь аймгийн төвд оршин сууж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод хамрагдсан 18 хүртэлх насны нийт хүүхдийн 83.4 хувь нь эцэг, эхтэйгээ эсвэл хэн нэгэнтэй нь хамт, үлдсэн 16.6 хувь нь эцэг, эхээсээ өөр асран хамгаалагчтай амьдардаг байна.

0-15 насны хүүхэдтэй өрхийн 46.8 хувь нь гэрт, 52.4 хувь нь байшинд, 0.8 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байгаа бөгөөд өрхөд тоологдсон хүүхдүүдийн 48.9 хувь нь гэрт, 50.3 хувь нь байшинд, 0.8 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.

Манай улсын харьяат 0-18 насны хүүхэд, залуучуудын 47.3 хувь нь буюу 10 хүн тутмын 5 нь, хүүхэдтэй нийт өрхөд тоологдсон энэ насны 10 хүн тутмын 5 нь гэрт амьдарч байна.

Зөөврийн ус хэрэглэдэг өрхөд тоологдсон 10 хүүхэд тутмын 5 нь 200 метр хүртэл зайнаас, 4 нь 200-1000 метр, мөн 10 хүүхэд тутмын 1 нь 1000 метрээс дээш зайнаас ус зөөдөг байна. Ус зөөдөг хүүхдүүдийн 45.9 хувь нь 7-15 насны хүүхдүүд байна.

Өрх тэргүүлэн амьдардаг 15-24 насны 52.4 мянган залуучуудын 68.4 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 18.3 хувь нь бусдын сууцыг түрээсэлж амьдарч байна. Өрхийн тэргүүлэгч энэ насны эрэгтэйчүүдийн 71.9 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 15.6 хувь нь бусдын сууцыг түрээсэлж амьдардаг бол эмэгтэйчүүдийн 54.5 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 28.7 хувь нь бусдын сууцыг түрээсэлж амьдарч байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод 6-14 насны 409.7 мянган хүүхэд тоологдсоны 60.3 хувь нь буюу 247.0 мянга нь боловсролгүй байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 90.5 хувь нь боловсролгүй ч бичиг үсэг мэддэг байна. 15-24 насны нийт залуучуудын 3.7 хувь нь ямар нэг боловсролгүй байгаагийн 58.9 хувь нь боловсролгүй ч бичиг үсэг мэддэг байна.

6-15 насны сургууль завсардсан 16.6 мянган хүүхдүүд тоологдсоны 63.0 хувь нь хөвгүүд, 37.0 хувь нь охид байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн бараг тал хувь нь 13-15 насны охид, хөвгүүд эзэлж байна. Мөн зургаан настнуудын сургууль завсардалт бусад насны бүлэгтэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд нийт завсардагчдын 16.0 хувийг эзэлж байна.

Тооллогод хамрагдсан 15-24 насны залуучуудын 96.3 хувь нь ямар нэг шатны боловсролтой байна. 15-24 насны залуучуудын боловсролын байдалд гарсан нэг том өөрчлөлт бол дээд боловсролтой залуучуудын тоо 1979 оныхоос 11 дахин, 1989 оныхоос 7 дахин, 2000 оныхоос 4.8 дахин өссөн явдал юм.

Монгол Улсын хэмжээнд тооллогод хамрагдсан 15 хүртэлх насны 9.5 мянган хүүхэд буюу нийт хүүхдийн 1.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 3 хүүхэд тутмын 2 нь төрөлхийн, 1 нь хөгжлийн олдмол бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны 14.3 мянган залуучууд байгаагийн 57.0 хувь нь эрэгтэйчүүд, 43.0 хувь нь эмэгтэйчүүд, насны хувьд 44.8 хувь нь 15-19 насны залуучууд эзэлж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод тоологдсон 15-24 насны 549.8 мянган залуучуудын 40.1 хувь нь эдийн засгийн идэвхтэй, тэдний хөдөлмөр эрхлэлтийн түвшин 67.3 хувь байна.

ДҮГНЭЛТ

Манай улсын хүн ам зүйн ачаалал буурч, хүн амын насны бүтэц идэршин хөдөлмөрийн насны хүн амын тоо эрс нэмэгдэж “хүн ам зүйн цонх үе” тохиож байгаа нь ажлын байрыг олноор нэмэгдүүлэх, ажиллах хүчний шингээлттэй, хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж сайтай эдийн засгийн өсөлт бий болгохыг зүй ёсоор шаардаж байна.

6-24 насны хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн түвшин дээшилж, ялангуяа хотын хүн ам бараг бичиг үсэгтэн болсон зэрэг олон дэвшил гарсан ч хөвгүүд, эрэгтэйчүүдийн боловсрол эзэмшиж буй байдал нь охид, эмэгтэйчүүдтэй харьцуулахад учир дутагдалтай болж, эрчүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүдийнхээсээ доошлох хандлага ажиглагдах болов. Энэ нь гэр бүл болон нийгмийн амьдралын бүхий л хүрээнд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улс 1990-ээд оны эхнээс сургууль завсардах явдал эрс нэмэгдэж, нэг хичээлийн жилд сургуулиас завсардсан хүүхдийн тоо нийт сурагчдын бараг 10 хувийг эзэлж байв. Өнөөдөр уг үзүүлэлт буурсан ч сургууль завсардсан хөвгүүдийн эзлэх хувийн жин охидынхоос өндөр хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хөдөлмөрлөх, нийгмийн амьдралд тэгш оролцох үндсэн эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээг цогц байдлаар авч үзэх шаардлага гарч байна. Түүнчлэн хүүхэд, залуучуудын дунд төрөлхийн сэтгэцийн бэрхшээл зонхилох хэлбэр болж байгаа нь удамшил, эцэг эхийн амьдралын хэвшил, зуршил (архи, тамхи хэрэглэх гэх мэт), эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны байдлаас хамаарч байгааг анхаарах хэрэгтэй юм. Нөгөөтэйгүүр, төрөлхийн болон хөгжлийн олдмол бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй байна. Үйлдвэрлэлийн болон ахуйн осол нь олдмол төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болдог гол шалтгаануудын нэг бөгөөд хүүхэд залуучууд осол гэмтэлд өртөх нь их байдаг.


Хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ сургуульд сурах сонирхолтой, хүсэлтэй залуучууд нэлээд байгаагаас 15-24 насны залуучуудыг цагийн ажил хийх боломжоор хангахад анхаарах хэрэгтэй нь харагдаж байна. Ажилгүй залуучуудын талаас илүү нь тохирох ажил олдохгүй гэж хариулсан залуучуудын болон ажиллах сонирхолгүй гэж хариулсан залуучуудын 60 гаруй хувь нь эрэгтэйчүүд байгаа нь гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас хохирох, осол, гэмтэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болохыг анхаарах шаардлагатай байна.

